

БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

“ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИТ, ӨМЧИЙН ОРОЛЦООТОЙ ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР АШИГ”

АУДИТЫН КОД: БУА/2022/22/4-ШТА-ГА

Аймаг суманд үйл ажиллагаа явуулж
байгаа ОНӨХХК, ОНӨААТҮГ-ын ТУЗ-
ийн дарга, гишүүд нь компаний
засаглалын дотоод журмыг
боловсруулж ажиллаагүй, тогтолцоо
харилцан адилгүй, дотоод хяналт сул
байна.

БУЛГАН АЙМАГ 2022 ОН

Булган аймаг дахь Төрийн аудитын газрын
Дарга, тэргүүлэх аудитор Б.Эрдэнэ
Утас: 70342580 Цахим хаяг:
Аудитын менежер Ж.Энхцоодол
Утас: 70342716 Цахим хаяг: Enkhtsoodolj@audit.gov.mn
Ахлах аудитор Д.Анхбаяр
Утас: 70342716 Цахим хаяг: Ankhbayard@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой
мэдээллийг дараах хаягаар авна уу.
Цахим хуудас www.audit.mn

АГУУЛГА

Товчилсон үгийн тайлбар	3
Хүснэгтийн товъёог	4
Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл	5-7
1.Орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой компаний засаглалыг хөгжүүлэх төрийн бодлого үр дүн багатай	9
1.1. Орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой хуулийн этгээд нь чиг үүргийнхээ дагуу үйл ажиллагаа явуулж байгаа ч компанийн засаглалын дотоод журам, аргачлалыг боловсруулж ажиллаагүй байна	9
1.1.1. Орон нутгийн өмчийн тухай хууль, холбогдох бусад хуулиуд компаний засаглалыг хөгжүүлэх хэрэгцээ шаардлагыг хангаж ажиллаагүй, ТУЗ-ийн гишүүд компаний засаглалын сургалтад хамрагдаж гэрчилгээ аваагүй байна	9
1.1.2. ТУЗ нь компаний засаглалыг үнэлэх үндэсний зарчим, аргачлал боловсруулж ажиллаагүй байна	9
1.1.3. Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа ХХК, ОНӨХХК, ОНӨААТҮГ-ууд нь холбогдох хууль, журмын дагуу чиг үүргээ хэрэгжүүлж байна	9
1.2. Засгийн газрын 2016-2020, 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгасан төрийн болон орон нутгийн өмчийн засаглалыг сайжруулах зорилтын үр дүн хангагдаагүй байна	10
1.2.1. Орон нутгийн өмчийн хуулийн этгээдийн компаний засаглалыг хөгжүүлэх бодлогыг ТУЗ боловсруулж ажиллаагүй	10
1.2.2. Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн төрийн болон орон нутгийн өмчийн засаглал, өмч хувьчлалын бодлогын талаарх асуудлыг аймгийн Засаг дарга 2016-2020 оны мөрийн хөтөлбөртөө тусгаагүй байна	10
1.2.3. Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт уялдуулан аймгийн Засаг даргын 2020-2024 оны мөрийн хөтөлбөрт төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл, ашиглалт, хамгаалалтыг сайжруулах, холбогдох журам заавраар сургалт өгөхөөр 3 асуудал төлөвлөж ажиллажээ	10
1.2.4. ХХК, ОНӨХХК, ОНӨААТҮГ-уудын ТУЗ-ийн тогтоол, шийдвэр үр нөлөө бага, зөвхөн жилийн төсөв, хөрөнгө бэлтгэх талаарх асуудлыг шийдвэрлэн ажиллажээ	11
2. Орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой хуулийн этгээдийн үйл ажиллагаа үр ашгийг төлөвлөгөөг зарим жил алдагдалтай төлөвлөж батлуулсан байна	11
2.1. Орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой хуулийн этгээдийн зорилтот түвшнийг хянан батлуулжээ	11
2.1.1.Орон нутгийн өмчит хуулийн этгээд эдийн засгийн зорилтот түвшнийг өмнөх оны үзүүлэлтэд үндэслэн төлөвлөжээ	12
2.1.2.Төрийн өмчит хуулийн этгээдийн эдийн засгийн зорилтот түвшнийг эрх бүхий байгууллага танилцаж хянасан нь тодорхой бус байна	12-13
2.1.3. Компани, ОНӨХХК, ОНӨААТҮГ-ын эрх бүхий этгээдүүд эдийн засгийн зорилтот түвшин, орлого, зарлага, ашиг алдагдалтай танилцаж ажилласан ч зарим байгууллага нь зардлыг дутуу, “Булган мээж” ОНӨХХК нь 2020, 2021 онуудын санхүүгийн төлөвлөгөөг алдагдалтай төлөвлөж батлуулсан байна	13

2.2.Орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой хуулийн этгээдийн орлого бүрдүүлэлт дутуу, эргэн төлөлтийн авлагыг бүрэн төвлөрүүлж ажиллаагүй байна.....	13
2.2.1. Холбогдох хуулийн этгээд төлөвлөсөн орлогоос өмнөх онд бичигдсэн 490.0 мянган төгрөгийн төлбөрийн актыг барагдуулж ажиллажээ.....	13
2.2.2. Улс, орон нутгийн төсөвт төвлөрүүлэх, төлбөр, хураамжийг зардлыг зарим ОНӨААТҮГ нь төлөвлөж ажиллаагүй, 2019-2020 онуудад татварт төлсөн гүйцэтгэлээр 3649.8 сая төгрөгийг төвлөрүүлж ажиллажээ.....	13-14
2.3.Орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой хуулийн этгээд нь үйл ажиллагааны зорилтот түвшиний дагуу ажилласан ч үр нөлөөг зарим газрууд нь тооцож ажилладаггүй, үргүй зардал гарган ажиллажээ.....	15
2.3.1. Санхүүгийн үйл ажиллагаанд үр ашгийн тооцоо, шинжилгээг бодитой хийгээгүй, зарим зардлыг дутуу төлөвлөж, алдагдалтай ажиллахаар үр ашгийн тооцоо хийсэн байна.....	15
2.3.2. Санхүүгийн үйл ажиллагааны үр ашгийн тооцоо, шинжилгээний үр нөлөөг “Булган мээж” ОНӨХХК-иас бусад ОНӨХХК, ОНӨААТҮГ-ууд дүгнэж ажиллаагүй байна.....	16
2.3.3.Харилцагч байгууллагуудтай гэрээ хийж ажиллаж байгаа ч үндэслэлгүйгээр гэрээний дүн, хувийг өөрчилж ажилласнаар 19.9 сая төгрөгийн үргүй зардалд зарцуулсан байна.....	16
2.4. Орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой хуулийн этгээдийн санхүүгийн үйл ажиллагаа, зардал үр ашгийн зохистой харьцааг хангаагүй, сүүлийн 3 жилийн дунджаар төлөвлөснөөсөө илүү зарцуулалт хийгдсэн байна.....	18
2.4.1. Удирдлагын зардлыг төлөвлөж байгаа ч зарим газрууд нь зардлыг төлөвлөж батлуулдаггүй, 2019-2021 онуудад 118.2 сая төгрөгийг илүү зарцуулжээ.....	18
2.4.2. Үйл ажиллагааны зардлыг бодиттой төлөвлөж ажиллаагүйгээс 2019-2021 онуудад 2252.8 сая төгрөгийн илүү зарцуулалттай, 227.0 сая төгрөгийн хэмнэлттэй ажилласан үзүүлэлтэй гарч байна.....	19
2.4.3. Шаардлагатай хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг зарим онуудад ОНӨААТҮГ-ууд төлөвлөж ажиллаагүй байна.....	19
3. Орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой хуулийн этгээдийн хяналт үр нөлөө бага байна.....	22
3.1. Санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн хөндлөнгийн хяналт үр нөлөө үзүүлснээр илэрхийлэгдэж байгаа ч үйл ажиллагаанд нь хийсэн хяналт хангалтгүй үзүүлэлтэй байна.....	22
3.1.1.Төрийн өмчит хуулийн этгээдийн үйл ажиллагаанд төрийн байгууллагуудад хяналт шалгалт хийсэн боловч хяналт шалгалтын материалыг хүргүүлж ажиллаагүй байна.....	22
3.1.2.Төрийн өмчит хуулийн этгээдийн санхүүгийн үйл ажиллагаанд тавих төрийн байгууллагуудын хяналт үр нөлөөтэй байна.....	22
3.2. Дотоод хяналтын тогтолцоо оновчгүй, хяналт үр нөлөө үзүүлж ажиллаагүйгээр илэрхийлэгдэж байна.....	23
3.2.1.ОНӨХХК, ОНӨААТҮГ-ууд нь ТУЗ-ын дэргэдэх хороо байгуулаагүй болно.....	23
3.2.2. Аймагт үйл ажиллагаагаа явуулж байгаа ХХК, болон ОНӨААТҮГ-уудын дотоод хяналтын ажилтан дотоод хяналт хийсэн гэх боловч үр дүн хангалтгүй байна.....	23
3.3.Мэдээллийн иж бүрэн, үнэн зөв, ил тод байдлыг хангаж ажилласан байна.....	23
3.3.1.Төрийн байгууллагуудын мэдээлэл уялдаатай байна.....	23

3.3.2.Төрийн өмчийн хуулийн этгээдийн мэдээлэл ил тод, нээлттэй байна.....	23
--	----

ДҮГНЭЛТ.....	24
---------------------	-----------

ЗӨВЛӨМЖ.....	25
---------------------	-----------

Товчилсон үгийн тайлбар

ОНӨХХК	Орон нутгийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компани
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ХААХИ	Хөдөө аж ахуй хөгжлийн ирээдүй
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ТУЗ	Төлөөлөн удирдах зөвлөл
ЭХЗХ	Эрчим хүчний зохицуулах хороо
СТСХ	Санхүү төрийн сангийн хэлтэс
ААНҮАТЗТХ	Аж ахуй нэгжийн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль
ТБОНӨХБАҮХА	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах
ТБОНӨТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
ТӨОХЭТӨТХЖ	Төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх журам
НББ	Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль

Төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой хуулийн этгээдийн үйл
ажиллагааны үр ашиг

Хүснэгтийн товъёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хүснэгт 1	Байгууллагын орон тоо, орлого, зарлага	10
Хүснэгт 2	2021 оны төлөвлөсөн орлого, орлогын гүйцэтгэл	12
Хүснэгт 3	Байгууллагуудын удирдлагын зардлын төлөвлөлт	17
Хүснэгт 4	“Булган мээж” ОНӨХХК-ний 2019-2021 оны зардлын гүйцэтгэл	18
Хүснэгт 5	ОНӨХХК, ОНӨАТҮГ-уудын 2019-2021 онуудын орлого, зарлага, ашиг алдагдлын гүйцэтгэл	19

Графикийн товъёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
График 1	“Тэшиг ус” ОНӨААТҮГ-ын өр авлага барагдуулалтын гүйцэтгэл	13
График 2	“Булган мээж” ОНӨХХК-ний татвар төлбөр хураамжийн зардлын тоон үзүүлэлт	13

Зургийн товъёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Зураг 1	Дулаан үйлдвэрлэлийн зуух	15

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх	Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл Аудитыг УИХ-ын Төсвийн байнгын хорооны 2021 оны 6 дугаар тогтоол, МҮЕА-ын 2022 оны А/12 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагын 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө”-ний дагуу төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд гүйцэтгэлийн аудит хийлээ.
Аудитын зорилт	Төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой зарим хуулийн этгээдийн компаний засаглал, үйл ажиллагааны үр ашиг, хяналтын үр нөлөөг үнэлж дүгнэн, аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн зөвлөмж боловсруулж холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилго чиглэгдлээ. Дээрх зорилгыг хангахын тулд дараах дэд зорилтын хүрээнд аудитыг гүйцэтгэлээ. Үүнд: - Компанийн засаглалыг хөгжүүлэх төрийн бодлого үр дүнтэй эсэх. - Төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой хуулийн этгээдийн үйл ажиллагаа үр ашигтай эсэх. - Төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой хуулийн этгээдийн хяналт үр нөлөөтэй эсэх.
Аудитын хамарсан хүрээ	Аудитад Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, Компаний тухай, хууль, УИХ, Засгийн газраас гаргасан тогтоол, тухайн хуулийн этгээдийн Төлөөлөн удирдах зөвлөлөөс гаргасан шийдвэр, бусад хууль, эрх зүйн баримт бичгийн хэрэгжилтийн хүрээнд Төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой хуулийн этгээдийн компанийн засаглал, үйл ажиллагааны үр ашиг, хяналтыг хэрэгжүүлэхэд ТУЗ, гүйцэтгэх удирдлага, холбогдох төрийн, мэргэжлийн байгууллага, агентлаг, тэдгээрийн ажлын албадын 2019-2021 онуудын үйл ажиллагааг хамрууллаа.
Аудитын хязгаарлалт	
Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт	Аудитыг гүйцэтгэлийн аудитын стандарт АДБОУС 3000-3100, Монгол Улсын Төрийн аудитын стандарт, Гүйцэтгэлийн аудитын үндсэн ойлголтын удирдамж УДИР 3910, УДИР 3920, Монгол Улсын Төрийн аудитын стандарт, MNS 6817-5:2020, “Гүйцэтгэлийн аудитын зарчим” MNS 6817-7:2020 “Гүйцэтгэлийн аудитын стандарт”, МҮЕА-ын баталсан “Гүйцэтгэлийн аудитын заавар, аргачлал”-ыг ашиглаж гүйцэтгэлээ. Аудитаар байгууллагын холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга, лавлагаа болон судалгаа авах, эдийн засгийн зорилтот түвшний төлөвлөлт, хяналт, санхүүгийн үйл ажиллагаа, үр ашигт, хяналтын тогтолцооны үр нөлөө зэрэг үйл ажиллагааны төлөвлөлт, хэрэгжилт болон бусад шаардлагатай баримт материалд тулган баталгаажуулалт, дүн шинжилгээ хийх горимыг хэрэгжүүлэх, асуудлын шинжилгээ, шалгах хуудасны дагуу нотлох зүйл цуглуулж аудитын дүгнэлт, зөвлөмжийг боловсрууллаа.

Аудитын бүрэлдэхүүн, хугацаа	Аудитыг Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Эрдэнэ хянан удирдаж, аудитын менежер Ж.Энхцоодол аудитын үе шатны чанарын хяналтыг хэрэгжүүлж, ахлах аудитор П.Мөнхтуяа, аудитор Б.Энхтөр нар хийж гүйцэтгэлээ. Аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу гүйцэтгэлийн аудитын талбарын ажлыг 2022 оны 05 дугаар сарын 10-ны өдрөөс 2022 оны 06 дугаар сарын 20-ны өдөр хүртэл гүйцэтгэж, тайлагналын ажлыг 2022 оны 06 дугаар сарын 27-ны өдөр дуусгавар болгон аудитыг үе шатны хяналтаар хянуулж, аудитын тайлан, нотлох баримтыг бэлтгэж ажиллалаа.
Хүндрэл бэрхшээл	Аймгийн хэмжээнд “Булган мээж” ОНӨХХК, “ХААХИ” ОНӨХХК, “Тэшиг ус” ОНӨААТҮГ, “Илчит хутаг” ОНӨААТҮГ-ууд аймгийн төв, Тэшиг, Хутаг-Өндөр сумдын төрийн болон аж ахуйн нэгж байгууллага, айл өрхийн дулаан, цэвэр ус түгээн нийлүүлж, эвдрэл, гэмтэл, засвар үйлчилгээг хариуцан ажиллаж байна.
Үндсэн мэдээлэл	“ХААХИ” ОНӨХХК нь анх аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2017 оны 02 дугаар сарын 17-ны өдрийн 25 дугаар тогтоолоор “Булган жимс жимсгэнэ” хөтөлбөр нэртэйгээр батлагдан аймаг, орон нутгийн иргэдийн “Өрх, фермерийн аж ахуй болон жижиг хоршоод, иргэд жимс, жимсгэний аж ахуй эрхлэх замаар ажлын байр бий болгож, өрхийн орлогоо нэмэгдүүлэх, ажилгүйдэл, ядуурлыг бууруулах, хүнсний хангамжийг нэмэгдүүлэх, улмаар цөлжилтийг сааруулах, байгаль экологийн тэнцвэртэй байдлыг хадгалах” зорилготойгоор 2016-2020 онд хэрэгжихээр батлагдсан. “ХААХИ ОНӨХХК нь 2017-2019 онуудад Шинэ хөдөө төсөл нэртэйгээр эхэлж улсын төсөв, байгаль хамгаалах сангийн төсвөөс нийт 4.7 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийсэн байна. Төслийг үр дүнтэй хэрэгжүүлэхийн тулд “Шинэ хөдөө-хөгжил” орон нутгийн өмчит, аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар байгуулж, мал аж ахуйг эрчимжүүлэх, чацаргана тариалах, төмс, хүнсний ногооны техникээр хангах, арьс шир боловсруулах үйлдвэр байгуулах зэрэгт хөрөнгө оруулалт хийж, хөдөөд ажлын байр бий болгоход чиглэж одоогоор иргэн, аж ахуй нэгж хамрагдаж үйл ажиллагаа явуулж байна. “Илчит хутаг” ОНӨААТҮГ нь Хутаг-Өндөр сумын дулаан, ус, хот тохижилтын ажлуудыг хариуцан ажиллаж 2019-2020 онуудад 28 орон тоогоор, жилийн орлого дунжаар 582.7 сая төгрөг, зарлага дунджаар 546.0 сая төгрөгийг зарцуулж дунджаар 36.7 сая төгрөгийн ашигтай ажилласан байна. “Тэшиг ус” ОНӨААТҮГ нь Тэшиг сумын дулаан, цэвэр ус, түгээх, засвар үйлчилгээний ажлуудыг хариуцан ажиллаж 2019-2020 онуудад 22 орон тоогоор, жилийн орлого дунжаар 302.1 сая төгрөг, зарлага дунджаар 304.4 сая төгрөгийг зарцуулж 2.3 сая төгрөгийн алдагдалтай ажилласан нь 2019 онд орлого тасарсантай холбон үзэж байна. “Булган мээж” ОНӨХХК нь “Иргэд, байгууллагын эрх ашгийг эрхэмлэн хүндэлж, эрүүл ахуйн стандарт хангасан цэвэр ус түгээн нийлүүлж, хэрэглэгчдийг найдвартай дулааны эрчим хүчээр ханган

ажиллах” гэсэн зорилгын хүрээнд “Хэрэглэгчдийг найдвартай дулаан эрчим хүчээр ханган ажиллах” зорилт тавин ажиллажээ.

Тус компани нь 2021 онд Захиргаа, санхүүгийн алба 15, Дулааны алба 27, ус сувгийн алба 33, нийт үндсэн 75 ажилтан, гэрээт 36 нийт 186 ажилтантайгаар үйл ажиллагаагаа явуулжээ.

2021 оны 09 дүгээр сарын 08-ны өдрийн аймгийн ИТХ-ын 63 дугаар тогтоолоор “Цэвэрлэх байгууламж” ашиглалтад орсноор 19 орон тоог шинээр бий болгож ажиллуулсан байна.

ТУЗ нь аймгийн ИТХ-ын 2020 оны 11 дүгээр сарын 24-ний өдрийн 12 дугаар тогтоолоор 7 гишүүний бүрэлдэхүүнтэй шинэчлэн томилуулжээ.

Төлөөлөн удирдах зөвлөл нь 2021 онд 8 удаа хуралдаж нийт 25 асуудал хэлэлцэж, 13 тогтоол гаргаж хэрэгжилтийг хангаж ажиллажээ.

“Булган мээж”ОНӨХХК-ний 2019-2020 оны орлого зарлагын төлөвлөлт: 2019 онд орлогыг 4143.7, зарлагыг 3866.1, ашиг алдагдлыг 277.6, 2020 онд орлогыг 4200.4, зарлагыг 4362.2, ашиг алдагдлыг (579548.4), 2021 онд орлогыг 4924.9, зарлагыг 4066.6, ашиг алдагдлыг (1808.2) сая төгрөгөөр төлөвлөсөн нь сүүлийн 2 жилд орлогоосоо илүү зардал төлөвлөн алдагдалтай төсөв баталсан байна.

Жил жилийн орлогын гүйцэтгэл: 2019 онд 4743.7, 2020 онд 4362.2, 2021 онд 4066.6 сая төгрөгийн орлого бүрдүүлж ажилласнаас 2019-2020 онуудад орлогыг 9 хувь буюу 761.8 сая төгрөгийг нэмэгдүүлж 2021 онд орлого 17.4 хувиар буурч орсон үзүүлэлтэй байна.

1.Орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой компанийн засаглалыг хөгжүүлэх төрийн бодлого үр дүн багатай.

1.1. Орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой хуулийн этгээд нь чиг үүргийнхээ дагуу үйл ажиллагаа явуулж байгаа ч компаний засаглалын дотоод журам, аргачлалыг боловсруулж ажиллаагүй байна.

1.1.1. Орон нутгийн өмчийн тухай хууль, холбогдох бусад хуулиуд компанийн засаглалыг хөгжүүлэх хэрэгцээ шаардлагыг хангаж ажиллаагүй, ТУЗ-ийн гишүүд компаний засаглалын сургалтад хамрагдаж гэрчилгээ аваагүй байна.

Орон нутгийн өмчит “Булган мээж” ОНӨХХК-ий ТУЗ-ийн 2019 онд ажиллаж байсан 7 гишүүн нь бүгд компаний засаглалын сургалтад хамрагдан гэрчилгээтэй байсан бол 2020-2021 онд томилогдсон 7 гишүүнээс 3 нь гэрчилгээтэй, 4 гишүүн нь гэрчилгээгүй, “ХААХИ” ОНӨХХК ТУЗ-ын 9, “Илчит хутаг” ОНӨААТҮГ ТУЗ-ын 5, “Тэшиг ус” ОНӨААТҮГ ТУЗ-ын 7 гишүүн нь компаний засаглалын сургалтад хамрагдаагүй байна.

Орон нутгийн өмчит компаниуд нь ТУЗ, гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагааны болон компанийн засаглалын дотоод журмыг тус тус боловсруулж, батлуулж, ажиллаагүй нь компаний тухай хуулийн 76.1.13.¹, 75.8² гэсэн заалтуудыг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй зөрчил илэрсэн тул аудитаар 2 зөвлөмж хүргүүлээ.

1.1.2. ТУЗ нь компаний засаглалыг үнэлэх үндэсний зарчим, аргачлал боловсруулж ажиллаагүй байна.

“Булган мээж” ОНӨХХК-ий ТУЗ нь компаний тогтолцоо, үйл явцыг үнэлэх зарчим, аргачлал, бодлого, чиглэлийг боловсруулж ажиллаагүй, үнэлж дүгнээгүй, үйл ажиллагааны ажлын төлөвлөгөө гаргаж ажиллаагүй, харин 2021 онд тус компаний бизнес төлөвлөгөөг боловсруулан ажиллажээ.

Иймд үйл ажиллагааг Санхүүгийн зохицуулах хорооны 2016 оны 134 дүгээр тогтоолоор баталсан “Компанид засаглалын үнэлгээ хийх, түвшин тогтоох журам”-ыг хэрэгжүүлэн үнэлж, түвшин тогтоох аргачлалыг боловсруулан, жилийн ажлын төлөвлөгөө батлуулж үйл ажиллагааны тайланг компаний дотоод дүрмийн 6.2-т “Төлөөлөн удирдах зөвлөл нь үйл ажиллагааныхаа тайланг жилд 2-оос доошгүй удаа, компаний ашгийн хуваарилалтын талаарх саналыг боловсруулж дараа оны 1 дүгээр улиралд багтаан үүсгэн байгуулагчийн хурлаар хэлэлцүүлнэ.” гэж заасныг хэрэгжүүлж ажиллах шаардлагатай байна.

1.1.3. Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа ХХК, ОНӨХХК, ОНӨААТҮГ-ууд нь холбогдох хууль, журмын дагуу чиг үүргээ хэрэгжүүлж байна.

“Булган мээж” ОНӨХХК, “ХААХИ” ОНӨААТҮГ, “Тэшиг ус” ОНӨААТҮГ, “Илчит хутаг” ОНӨААТҮГ-ууд нь ТБОНӨ-ийн тухай хууль, компаний тухай хууль, байгууллагын дүрэм, журам, ИТХ-ын тогтоол, бусад холбогдох хууль тогтоомжийг хэрэгжүүлэн аймаг, сумдын дулаан, цэвэр усаар ханган ажиллаж байна.

Тухайлбал: “Булган мээж” ОНӨХХК нь 2005 оны 10 дугаар сарын 31-ний 000150252 гэсэн улсын бүртгэлийн гэрчилгээнд “Хот суурин ус хангамж, ариутгах, татуургын ашиглалт засвар, үйлчилгээ”, “Дулаан үйлдвэрлэх, түгээх, дулаанаар зохицуулалттай хангах”, Барилгын угсралт, өргөтгөл, шинэчлэлийн ажил, ус, хангамж ариутгах татуургын болон дулааны магистраль, шугам сүлжээ, түүний тоног төхөөрөмжийн угсралт, цахилгаан хангамжийн болон бусад шугам сүлжээний угсралтын ажил” гэсэн чиглэлүүд тусгагдсаны дагуу үйл ажиллагаагаа явуулж байна.

Тус компани нь байгууллагын дүрмийг 2020 оны 08 дугаар с арын 30-ны өдрийн аймгийн ИТХ-ын 30 дугаар тогтоолоор, хөдөлмөрийн дотоод журмыг 2021 оны 01 дүгээр

¹ “Төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагааны болон компанийн засаглалын дотоод журмыг батлах;

² “Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн болон төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга нь компанийн засаглалын чиглэлээр сургалтад хамрагдаж, гэрчилгээ авсан байна

сарын 28-ны өдрийн байгууллагын даргын А16 тоот тушаалаар тус тус шинэчлэн баталжээ.

1.2. Засгийн газрын 2016-2020, 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгасан төрийн болон орон нутгийн өмчийн засаглалыг сайжруулах зорилтын үр дүн хангагдаагүй байна.

1.2.1. Орон нутгийн өмчийн хуулийн этгээдийн компаний засаглалыг хөгжүүлэх бодлогыг ТУЗ боловсруулж ажиллаагүй байна.

“ХААХИ” ОНӨХХК нь 2020 онд, “Булган мээж” ОНӨХХК, “Тэшиг” ОНӨААТҮГ нь байгууллагын бизнес төлөвлөгөөг 2021 онд тус тус боловсруулж ажилласан, “Илчит хутаг” ОНӨААТҮГ нь бизнес төлөвлөгөөг боловсруулж ажиллаагүй байна.

Дээрх орон нутгийн өмчит хуулийн этгээдийн ТУЗ компаний засаглалыг хөгжүүлэх бодлого боловсруулаагүй байна.

1.2.2. Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн төрийн болон орон нутгийн өмчийн засаглал, өмч хувьчлалын бодлогын талаарх асуудлыг аймгийн Засаг дарга 2016-2020 оны мөрийн хөтөлбөртөө тусгаагүй байна.

Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 5.2.1-д “Төрийн болон орон нутгийн өмчийн ашиглалт, төрийн болон орон нутгийн өмчит компаниудын ашигт ажиллагаа, засаглал, өмч хувьчлалын бодлогыг сайжруулж, төр, хувийн хэвшлийн түншлэлийг шинэ шатанд гаргана.” гэж заасны дагуу аймгийн Засаг даргын мөрийн хөтөлбөр, зорилтын хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээнд тусгаж ажиллаагүй байна.

Аймгийн Засаг даргын 2016-2020 оны “Хөгжлийн хөтөч” үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт “Шинэ хөдөө” төслийн хүрээнд “Чацаргана хөтөлбөрийг шинэчлэн боловсруулах”, “Малын үржлийн удмын санг сайжруулах, ашиг шимийг нэмэгдүүлэх”, “Усалтын системийн ашиглалтыг сайжруулах, дэвшилтэт технологи нэвтрүүлэх замаар усалгаатай тариалангийн хэмжээг нэмэгдүүлэх”, гэсэн зорилтуудыг хэрэгжүүлэхээр тусгасан байна.

Үүний үр дүнг 2021 онд хийгдсэн гүйцэтгэлийн аудитаар дүгнэхэд: Шинэ хөдөө төслийн хүрэх үр дүн, зорилтыг төлөвлөж тооцоо судалгаа гаргаж ажилласан ч иргэдийн хэрэгцээ шаардлагад нийцээгүй, авлагын гүйцэтгэл 13 хувьтай байгаа нь найдваргүй авлага үүсэх магадлалтай, түүвэрлэлтэд хамрагдсан 9 сумын чацарганы ургац 10-40 хувьтай ургасан нь ургац хангалтгүй үзүүлэлтэй, эзэнжүүлээгүй тоног төхөөрөмж айл, өрх болон сумдын ЗДТГ-т хадгалагдаж байгаа нь бүтээмж муутай, өндөр үнэтэй тоног төхөөрөмж нийлүүлсэнтэй холбоотой холбон үзэж төслийн хэрэгжилтийг хангалтгүй гэж дүгнэсэн байна.

1.2.3. Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт уялдуулан аймгийн Засаг даргын 2020-2024 оны мөрийн хөтөлбөрт төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл, ашиглалт, хамгаалалтыг сайжруулах, холбогдох журам заавраар сургалт өгөхөөр 3 асуудал төлөвлөж ажиллажээ.

Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 4.4.10-т “Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл, ашиглалт, хамгаалалтыг сайжруулж, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн засаглалыг олон улсын жишигт нийцүүлэх, газрын хууль тогтоомжийг төрийн байгууламж нэгдмэл байх зарчим болон өмчийн эрх зүйд нийцүүлэн боловсронгуй болгоно.” гэж тусгагдсаны дагуу аймгийн Засаг даргын 2020-2024 оны “Шинэ хөгжлийн зам” үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийн 2.1.6-д “Аж ахуйн нэгж, байгууллагын бүртгэл хөтлөлт, олон улсын стандарт нэвтрэлтийг сайжруулах замаар төсвийн орлогын бүрдүүлэлт, төсвийн зарцуулалтын үр ашгийг дээшлүүлж, удирдлагын бүх шатанд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн оновчтой шийдвэр гаргаж, хэрэгжүүлнэ.” гэж заасан нь Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөртэй уялдуулан зорилт тавьж төлөвлөсөн байна.

Тус зорилтын хүрээнд 3 арга хэмжээ авч ажиллахаар мөрийн хөтөлбөрт тусган 2021 оны 11 дүгээр сарын 15-ны байдлаар товч тайлан гарган ажиллажээ.

Үүнд: 1. Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Бүртгэлийн олон улсын стандарт, холбогдох заавар журмын хэрэгжилтийг хангах

2. Төсвийн гүйцэтгэлд дүн шинжилгээ хийж зөвлөмж гаргах, эрсдэлийн удирдлагаар хангах

3. Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт нэвтрэлтийг сайжруулах хүрээнд аж ахуйн нэгж байгууллагын бүртгэл хөтлөлтөд хяналт тавих, зөвлөн туслах гэсэн асуудлуудын хэрэгжилтэд Төсвийн шинэчлэл, цалингийн нэгдсэн системийн хэрэгжилт, Засгийн газар, Сангийн яамнаас хэрэгжүүлж буй бодлого, арга хэмжээг орон нутгийн түвшинд хэрэгжүүлэн ажилласнаар төсвийн үр ашиг дээшилж байгаа эерэг үр дүнгүүд гарч байна гэж асуудал тус бүрийн хэрэгжилтийг 90 хувьтай ажилласан гэж дүгнэжээ.

1.2.4. ХХК, ОНӨХХК, ОНӨААТҮГ-уудын ТУЗ-ийн тогтоол, шийдвэр үр нөлөө бага, зөвхөн жилийн төсөв, хөрөнгө бэлтгэх талаарх асуудлыг шийдвэрлэн ажиллажээ.

“Булган мээж” ОНӨХХК, “Тэшиг ус” ОНӨААТҮГ, “Илчит хутаг” ОНӨААТҮГ-ууд ТУЗ-ийн бүрэлдэхүүн хэсэг, үндсэн хөрөнгө худалдан авах, актлах, эзэмших, төсөв хөрөнгөтэй холбоотой асуудлыг аймаг, сумын ИТХ, байгууллага, компаний ТУЗ-аар шийдвэрлүүлэн холбогдох тогтоол, шийдвэрийг гарган ажиллаж байна.

Гэвч зарим компани, газрууд нь алдагдалтай төсөв баталсан, үндсэн хөрөнгө худалдан авах төлөвлөгөө боловсруулаагүй, үндсэн хөрөнгө худалдан авсан зэрэг зөрчлүүд аудитаар илэрлээ.

Тухайлбал: “Булган мээж” ОНӨХХК нь 2020 онд орлогыг 4200.4, зарлагыг 4362.2, ашиг алдагдлыг (579548.4), 2021 онд орлогыг 4924.9, зарлагыг 4066.6, ашиг алдагдлыг (1808.2) сая төгрөгөөр төлөвлөсөн нь сүүлийн 2 жилд орлогоосоо илүү зардал төлөвлөн алдагдалтай төсөв баталсан ч 2019 онд 14, 2020-2021 онд 7 удаагийн нийт 53 асуудлыг хэлэлцэж компаний хөрөнгө, санхүүтэй холбоотой асуудлыг шийдвэрлэж, компаний засаглалын сургалтад ТУЗ-ийн дарга, нарийн бичиг, 1 гишүүний гэрчилгээтэй, өр авлага шийдвэрлүүлэхээр албан тоот хүргүүлэн ажиллажээ.

“Тэшиг ус” ОНӨААТҮГ нь 2021 оны жилийн төлөвлөгөөнд тусгаагүй 2.3 сая төгрөгийн үндсэн хөрөнгө бэлтгэсэн, ТУЗ-ийн дарга, гишүүд тогтворгүй 2020 онд байгууллагын дарга солигдсон, гишүүд хуралдаандаа бүрэн бүрэлдэхүүнээрээ цуглардаггүй нь урамшуулал байхгүй, сайн дураараа сонгогдог тул идэвх санаачилга муу гэсэн тайлбарыг аудитын явцад өгч байсан.

Жилд дунжаар 2020-2021 онд 4-5 тогтоол гарч ажилласан нь төсөв батлах, орон тоо батлах, цалин урамшууллыг нэмэх тухай тогтоол гарч ажилласнаас шийдвэрлэж бодитой хэрэгжсэн ажил байхгүй байна.

“Илчит хутаг” ОНӨААТҮГ нь 2019 5, 2020 онд 6, 2021 онд 5 тогтоол тус тус гарсан нь тус байгууллагын бүтэц орон тоо, санхүүгийн төлөвлөгөө, цалин урамшуулалтай холбоотой тогтоол шийдвэрүүд гарснаас томоохон ажлуудын талаар шийдэгдсэн тогтоол гараагүй байна.

ХААХИ ОНӨХХК 2020 онд 6, 2021 онд 11 тогтоол гарсан нь бүтэц, орон тоо, бизнес төлөвлөгөө, түрээсийн төлбөрийн хэмжээ батлах тухай, дотоод журам батлах тухай, цалин, урамшуулал олгох тухай, эд хөрөнгө түрээслүүлэх журам батлах тухай зэрэг тогтоол гарган ажиллажээ.

2. Орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой хуулийн этгээдийн үйл ажиллагаа үр ашгийн төлөвлөгөөг зарим жил алдагдалтай төлөвлөж батлуулсан байна.

2.1. Орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой хуулийн этгээдийн зорилтот түвшнийг хянан батлуулжээ.

2.1.1. Орон нутгийн өмчит хуулийн этгээд эдийн засгийн зорилтот түвшнийг өмнөх оны үзүүлэлтэд үндэслэн төлөвлөжээ.

Аймагт үйл ажиллагаагаа явуулж буй “Булган мээж” ОНӨХХК, “Тэшиг ус” ОНӨААТҮГ-ууд нь жил бүр ТУЗ-ийн тогтоолоор бүтэц орон тоо, санхүүгийн төлөвлөгөө, эдийн засгийн үр ашиг, тухайн жилийн зардал, хөрөнгө оруулалт, ажилчдын нийгмийн асуудал зэрэг асуудлыг төлөвлөн батлуулж ажиллажээ.

Үүнд: “Булган мээж” ОНӨХХК нь 2019 онд ТУЗ-ийн 05, 2020 онд 04, 2021 онд 04 дүгээр, “Тэшиг ус” ОНӨААТҮГ нь 2020 онд 05, 2021 онд 07, “Илчит хутаг” ОНӨААТҮГ нь 2019 онд 10, 2020 онд 10/07, 2021 онд 02/09 тоот тогтоолуудаар батлуулж, төсөв төлөвлөгөөг боловсруулахдаа өмнөх оны тоо мэдээлэл, судалгаанд үндэслэж төлөвлөжээ.

Байгууллагын орон тоо, жилийн орлого, зарлага, ашиг алдагдлыг тоон үзүүлэлтээр, байгууллага тус бүрээр нь харуулбал:

Хүснэгт 1			/мян.төг/			
№	Төрөл	Он	“Булган мээж” ХХК	“Тэшиг ус” ОНӨААТҮГ	“Илчит хутаг” ОНӨААТҮГ	“ХААХИ” ОНӨХХК
1	Орон тоо	2019	183	24	34	3
2		2020	130	22	28	3
3		2021	130	22	28	3
4	Орлого	2019	4143.8	283.7	577.0	0
5		2020	4200.4	319.8	541.5	222.8
6		2021	4924.9	381.4	615.9	195.8
7	Зарлага	2019	3866.1	291.1	541.5	0
8		2020	4603.1	318.9	510.8	72.9
9		2021	6582.7	374.2	552.9	128.1
10	Ашиг алдагдал	2019	277.6	-7.4	2.3	0
11		2020	-579.5	1.0	2.9	10.6
12		2021	-1808.2	7.2	25.1	13.2

Орон тооны хувьд “Булган мээж” ХХК нь 2019-2020 оны хооронд 53 ажилтан хасагдсан нь аймагт дулааны станц ашиглалтад орсноор 3 уур зуухны үйл ажиллагааг зогсоосонтой холбоотой байна.

“Илчит хутаг” ОНӨААТҮГ нь 2019-2020 онуудын ашиг алдагдлаас 2021 онд 11.5 хувиар илүү төлөвлөсөн нь сумын төвд шинээр цэцэрлэгийн барилга ашиглалтад орохтой холбогдуулан төлөвлөжээ.

“ХААХИ” ОНӨХХК нь анх 2019 оны 09 дүгээр сарын 24-ний өдрийн ИТХ-ын тэргүүлэгчдийн 97 тоот хуралдаанаар “Нутгийн хөгжил” ОНӨААТҮГ нэртэйгээр үүсгэн байгуулагдаж шинэ хөдөө төслөөр олгогдсон жимс жимсгэнэ, тоног төхөөрөмжийн эргэн төлөлтүүд 2020 оны 02 дугаар сараас төлөгдөхөөр гэрээ хийсэн тул 2019 онд орлого зарлагыг төлөвлөж ажиллаагүй, 2020, 2021 онуудын орлого, зарлагыг төслөөр эргэн төлөлтийн орлогоос төлөвлөсөн байна.

2.1.2. Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн эдийн засгийн зорилтот түвшнийг эрх бүхий байгууллага танилцаж ажилладаг ч ямар үндэслэлээр хянасан нь тодорхой бус байна.

Аймаг, суманд үйл ажиллагаагаа хэрэгжүүлж байгаа ОНӨХХК болон ОНӨААТҮГ-ын 2019-2021 онуудын жилийн эдийн засгийн зорилтот түвшин, орлого, зарлагын төлөвлөсөн төсөвтэй ТУЗ-ын дарга, гишүүд байгууллагын дарга, эдийн засагч, нягтлан бодогч нартай хуралдан асуух, хариулт хэлбэрээр төсөв, төлөвлөгөөтэй танилцаж хурлын тэмдэглэлээр баталгаажуулан ажилладаг нь тухайн төсвийг ямар үндэслэл, шалгуураар хянадаг нь тодорхой бус байна.

“Илчит хутаг” ОНӨААТҮГ нь эдийн засгийн зорилтот түвшин, орлого, зарлагын төлөвлөгөөгөө байгууллагын дүрмийн 4.1³, 4.3⁴ гэж заасны дагуу сумын ИТХ-д танилцуулж байгаа ч тус дүрмийг 2015 оноос хойш шинэчлээгүй, компаний тухай хуулийн 2.4-д⁵ гэсэн заалтыг хэрэгжүүлээгүй байна.

2.1.3. Компани, ОНӨХХК, ОНӨААТҮГ-ын эрх бүхий этгээдүүд эдийн засгийн зорилтот түвшин, орлого, зарлага, ашиг алдагдалтай танилцаж ажилласан ч зарим байгууллага нь зардлыг дутуу, “Булган мээж” ХХК нь 2020, 2021 онуудын санхүүгийн төлөвлөгөөг алдагдалтай төлөвлөж батлуулсан байна.

Компани болон ОНӨХХК, ОНӨААТҮГ-ын баталсан дүнг хүснэгт 1-ээс үзэхэд “Булган мээж” ОНӨХХК нь 2020 онд 579548.4, 2021 онд 1818237.1 мянган төгрөгөөр, “Тэшиг ус” ОНӨААТҮГ нь 2019 онд 7368.5 мянган төгрөгөөр алдагдалтай ажиллахаар санхүүгийн төлөвлөгөөг баталжээ.

“Булган мээж” ХХК нь 2019 онд ТУЗ-ийн 05, 2020 онд 04, 2021 онд 04 дүгээр, ХААХИ ОНӨХХК нь 2020 онд 04, 2021 онд 03, “Тэшиг ус” ОНӨААТҮГ нь 2020 онд 05, 2021 онд 07, “Илчит хутаг” ОНӨААТҮГ нь 2019 онд 10, 2020 онд 10/07, 2021 онд 02/09 тоот тогтоолуудаар батлуулж, санхүүгийн төлөвлөгөөг боловсруулахдаа өмнөх оны тоо мэдээлэл, судалгаанд үндэслэж төлөвлөж байгаа ч алдагдалтай төсөв баталсан, зарим газрын тогтоол, шийдвэрийн он, сар, өдөр, тавигдаагүй, холбогдох баримт материал нь задгай, цэгцгүй, ажилчдын НДШ-ийг дутуу төлөвлөсөн байна.

Тухайлбал: “Тэшиг ус” ОНӨААТҮГ нь 2020 онд 4, 2021 онд 5 тогтоолуудыг гаргаж ажилласан, тогтоол шийдвэрт он сар өдөр тавигдаагүй, дутуу, уг баримтуудыг архивын нэгж болгон үдэж цэгцлээгүй, задгай, мөн байгууллагын дүрэм, бизнес төлөвлөгөөг 2018 оноос, дотоод журмыг 2019 оноос хойш шинэчлэн боловсруулж ажиллаагүй зөрчлүүд илэрсэнд зөвлөмж хүргүүлжээ.

Мөн “Тэшиг ус” ОНӨААТҮГ нь 2019-2021 онуудад галчаар ажилладаг 8 ажилтны 8 сарын НДШ-ийг төлснөөр тайлагнадаг, үлдсэн 4 сарын шимтгэлийг төлөөгүйгээс, 2020, 2021 онуудын 3144.9 мянган төгрөгийн шимтгэлийг төлөвлөж батлуулаагүй байна.

Энэ нь нийгмийн даатгалын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 7-д⁶, 16 дугаар зүйлийн 8-д⁷ гэсэн заалтуудыг хэрэгжүүлж ажиллаагүй, ирэх 2022 оны төсөвт НДШ-ийг бүрэн хэмжээгээр нь галч нарын сул зогсолтын 2552.0 мянган төгрөгийн /79750*4*8хүн/ шимтгэлийг байгууллагаас төлөхөөр нэмж тусгаж батлуулан ажиллах шаардлага үүсэж байгаа тул албан шаардлага хүргүүлж ажиллалаа.

Тус байгууллагад 2020 онд шалгасан гүйцэтгэлийн аудитаар алдагдалтай санхүүгийн төлөвлөгөө төлөвлөж батлуулсан зөрчилд зөвлөмж хүргүүлж ажиллаж байсан байна.

2.2. Орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой хуулийн этгээдийн орлого бүрдүүлэлт дутуу, эргэн төлөлтийн авлагыг бүрэн төвлөрүүлж ажиллаагүй байна.

2.2.1. Холбогдох хуулийн этгээд төлөвлөсөн орлогоос өмнөх онд бичигдсэн 490.0 мянган төгрөгийн төлбөрийн актыг барагдуулж ажиллажээ.

Аймаг суманд үйл ажиллагаа явуулж байгаа ХХК, ОНӨХХК, ОНӨААТҮГ-уудын 2019-2021 онуудад төлөвлөсөн орлого, орлогын хүснэгтээр харуулбал:

Хүснэгт -2

/сая.төг/

№	Байгууллагын нэрс	2019 он			2020 он			2021 он		
		Орлогын төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Орлогын төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Орлогын төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү

³ Үйлдвэрийн газрын эрх барих дээд байгууллага нь ИТХ байна.

⁴ тухайн жилийн төсвийн төсөөлөлтэй танилцаж батлах

⁵ Төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой компанид төрийн болон орон нутгийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх журмыг Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиар, төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнийг сонгох, гүйцэтгэх удирдлагыг томилох, төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх хороо, төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга болон тэдгээрийн үйл ажиллагаатай холбогдсон харилцааг энэ хуулиар зохицуулна

⁶ Хуанлийн жилд 7 сараас доошгүй хугацаагаар улирлын чанартай ажил, үйлчилгээ эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллагад хөдөлмөрийн гэрээгээр ажилладаг ажилтныг жилийн туршид нийгмийн даатгалд даатгуулсанд тооцно

⁷ Энэ зүйлийн 7 дахь хэсэгт заасан ажилтны нийгмийн даатгалын шимтгэлийг энэ хуулийн 15 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан ажил олгогчийн төлөх шимтгэлийн хувь хэмжээгээр төлнө.

Төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой хуулийн этгээдийн үйл ажиллагааны үр ашиг

1	"Булган мээж" ХХК	4143.8	4743.7	599.9	4200.4	4362.2	161.8	4924.9	4066.6	-858.3
2	"Тэшиг ус" ОНӨААТҮГ	283.7	198.9	-84.8	319.8	309.8	-10.0	381.4	397.8	16.4
3	"Илчит хутаг" ОНӨААТҮГ	577.0	543.8	-33.2	541.5	574.1	32.6	615.9	630.3	14.4
4	"ХААХИ" ОНӨХХК	0	0	0	222.8	96.8	-126.0	195.8	158.6	-37.2

Дээрх хүснэгтээс үзэхэд зарим ААН-үүд нь жилийн орлогоо илүү, дутуу төлөвлөсөн байна.

Эдгээрийн шалтгаан нь "Булган мээж" ОНӨХХК нь 2019 онд 599.9, 2020 онд 161.8 сая төгрөгөөр, "Илчит хутаг" ОНӨААТҮГ нь 2020 онд 32.6 сая төгрөгөөр орлого илүү оруулсан нь нэмэлт дулааны ажлууд хийгдсэнтэй холбоотой байна.

"Тэшиг ус" ОНӨААТҮГ нь 2019 онд 84.8 сая төгрөгөөр орлого тасарсан нь зарим аж ахуй нэгж үйл ажиллагаа явуулаагүй, орлогыг илүү төлөвлөсөн, 2021 онд 16.4 сая төгрөгөөр орлогыг илүү оруулсан нь сумын сургууль, цэцэрлэгийн барилга шинээр баригдаж ашиглалтад орсонтой холбоотой байна.

Тус газар нь 2021 оны үйл ажиллагааны орлогоос өмнөх оны аудитаар бичигдсэн 490.0 мянган төгрөгийн төлбөрийн актыг барагдуулж ажилласан зөрчил илэрсэн тул төлбөрийн акт тогтоож ажиллалаа.


"ХААХИ" ОНӨХХК нь нийт эргэлтийн хөрөнгийн 1285.2 сая төгрөгийн авлагаас 2020 онд 222.8, 2021 онд 195.8 сая төгрөгийг тус тус төлөвлөж, гүйцэтгэлээр 2020 онд 96.8, 2021 онд 158.6 сая төгрөгийн эргэн төлөлтийн орлого орсон нь нийт авлагын 19.8 хувийг эзэлж байгаа нь эргэн төлөлтийн орлого дутуу төвлөрсөн байна.

2.2.2. Улс, орон нутгийн төсөвт төвлөрүүлэх, төлбөр, хураамжийн зардлыг зарим ОНӨААТҮГ нь төлөвлөж ажиллаагүй, 2019-2020 онуудад татварт төлсөн гүйцэтгэлээр 3649.8 сая төгрөгийг төвлөрүүлж ажиллажээ.

"Булган мээж" ОНӨХХК, "ХААХИ" ОНӨХХК, "Тэшиг ус" ОНӨААТҮГ, "Илчит хутаг" ОНӨААТҮГ-ууд нь орон нутгийн төсөвт төвлөрүүлэх татвар, төлбөрийн хураамжийн зардалд аудит хийхэд татварт өглөг авлагагүй, ХХОАТ дутуу тооцсон, зарим ОНӨААТҮГ-ууд нь төлбөр хураамжийн зардлыг төлөвлөөгүй, зарим газрууд нь төлбөрийн хураамжийн зардлыг цаг тухайд нь төлсөн үзүүлэлтэйгээр тайлагнан, аймгийн шилдэг татвар төлөгчөөр шалгарсан байна.

Үүнээс: "Тэшиг ус" ОНӨААТҮГ нь 2020, 2021 оны зардлын төлөвлөгөө, гүйцэтгэлд аудит хийхэд банкны зээлийн өр, татварын өрийн үлдэгдлийг төлөвлөснөөсөө илүү төлөлт хийж банкны зээлийн өрийг бүрэн барагдуулан, татварын өрийг 83 хувиар багасгаж ажилласнаар 2021 онд "Аймгийн шилдэг татвар төлөгч байгууллага"-аар шалгарсан байна.

Үүнийг графикаар харуулбал:




Дээрх өрийн үлдэгдэл багассан нь дулаан, цэвэр бохир усны үнэ болон сарын халаалтын орлого нэмэгдсэнтэй, мөн цалин, НДШ-ийг хэмнэсэнтэй холбоотой байна.

Тус байгууллага нь 2020-2021 онуудад НӨАТ-ын татварт 82.7 сая төгрөгийг төвлөрүүлэн өмнөх оны өглөгийг бүрэн барагдуулж ажилласан, “Илчит хутаг” ОНӨААТҮГ нь 2021 оны эцсээр татварт 0.6 сая төгрөгийн өглөгтэй тус тус тайлагнасан байна.

“Тэшиг ус” ОНӨААТҮГ, “Илчит хутаг” ОНӨААТҮГ-ууд нь төлбөр хураамжийн зардлыг төлөвлөөгүй байна.

“Булган мээж” ОНӨХХК-ний 2019-2021 онуудын татвар, төлбөр хураамжийн зардлыг тоон үзүүлэлтээр графикаар харуулбал:



Графикаас үзэхэд 2019-2021 онуудад 6 төрлийн 3567.1 сая төгрөгийг татвар, төлбөр хураамжийн зардалд төвлөрүүлэн ажилласан ч 2021 онд хувь хүнээс 2071.0 мянган төгрөгийн материал худалдан авсан боловч 207.1 мянган төгрөгийн ХХОАТ-ыг суутган тооцоогүй зөрчил аудитаар илэрсэнд төлбөрийн акт тогтоолоо.

“Тэшиг ус” ОНӨААТҮГ нь өөрийн гэсэн үндсэн хөрөнгө байхгүй, сумын ЗДТГ-ын 10 нэр төрлийн 1093232.7 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг “Өмч эзэмшигчийн гэрээ” байгуулан ашиглуулж, дахин үнэлгээгээр 2020 онд 94019.3, 2021 онд 172872.1 мянган төгрөгөөр тус тус нэмэгдэж, нийт үндсэн хөрөнгийн 1314375.9 мянган төгрөгийн элэгдэл хасагдаж 45748.2 мянган төгрөгийн үлдэгдэх өртөгтэй хөрөнгө эзэмшүүлж байна.

“Тэшиг ус” ОНӨААТҮГ нь санхүүгийн тайлан бүртгэл, тодруулга тайланд өмч ашиглах гэрээгээр ашиглаж байгаа үндсэн хөрөнгийг тайланд бүртгээгүй, 1314.4 сая төгрөгийн элэгдлийн зардлыг тооцож ажиллаагүй, ашигтай ажилласнаар орлого үр дүнгийн тайланд тусгагдсан нь Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 17.6-д⁸, 17.10-т⁹, 17.11-д¹⁰ гэсэн заалтуудыг хэрэгжүүлж ажиллаагүй, санхүүгийн тайлан болон татварын тайлан, байгууллагын ашиг алдагдал буруу, татварт илүү татвар төлсөн байна.

2.3. Орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой хуулийн этгээд нь үйл ажиллагааны зорилтот түвшний дагуу ажилласан ч үр нөлөөг зарим газрууд нь тооцож ажилладаггүй, үргүй зардал гаргасан байна.

2.3.1. Санхүүгийн үйл ажиллагаанд үр ашгийн тооцоо, шинжилгээг бодитой хийгээгүй, зарим зардлыг дутуу төлөвлөж, алдагдалтай ажиллахаар үр ашгийн тооцоо хийсэн байна.

Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа “Булган мээж” ХХК, “ХААХИ” ОНӨХХК, “Тэшиг ус” ОНӨААТҮГ, “Илчит хутаг” ОНӨААТҮГ-уудын санхүүгийн үйл

⁸ Элэгдэл, хорогдол тооцох хөрөнгийн тодорхой хэсэг нь албан татвар ногдох орлого олоход ашиглагдаж байвал элэгдэл, хорогдлыг тухайн хэсэгт хувь тэнцүүлэн тооцож, албан татвар ногдох орлогоос хасна.

⁹ Түрээслэгчийн ашиглах эрхтэй хөрөнгийн нийт үнийг гэрээний хугацаанд төлөх түрээсийн төлбөрийн нийлбэр дүнгээр тооцож, гэрээний хугацаагаар элэгдэл байгуулна

¹⁰ Албан татвар төлөгчийн тухайн улиралд шинээр эзэмшсэн хөрөнгийн элэгдэл, хорогдлын шимтгэлийг дараагийн сарын эхний өдрөөс эхлэн тооцно

ажиллагаанд үр ашгийн тооцоо, шинжилгээнд аудит хийхэд зарим байгууллага нь үр ашгийг алдагдалтай ажиллахаар төлөвлөж, зарим жилдээ зардлыг дутуу төлөвлөж тооцсон, үр ашгийг нарийвчлан гаргаагүй нь санхүүгийн үйл ажиллагаанд үр ашгийн тооцоо шинжилгээ хангалтгүй байна.

Тухайлбал: “Илчит хутаг” ОНӨААТҮГ нь 2019-2021 онуудад удирдлагын зардал төлөвлөөгүй, “ХААХИ” ОНӨХХК нь 2020, 2021 онд хөрөнгө оруулалтын төлөвлөгөө, зардлыг “Тэшиг ус” ОНӨААТҮГ нь 2021 онд хөрөнгө оруулалтын зардлыг тус тус төлөвлөөгүй дутуу тооцож ажилласан байна.

“Булган мээж” ОНӨХХК-ний хувьд жилийн орлого зардлыг нэр төрлөөр өмнөх оны тоо мэдээ шинжилгээнд үндэслэж нарийвчлан тооцсон боловч 2020 онд (5779.5), 2021 онд (1808.2) сая төгрөгийн алдагдалтай ажиллахаар төлөвлөсөн байна.

2.3.2. Санхүүгийн үйл ажиллагааны үр ашгийн тооцоо, шинжилгээний үр нөлөөг “Булган мээж” ОНӨХХК-иас бусад ОНӨХХК, ОНӨААТҮГ-ууд дүгнэж ажиллаагүй байна.

Орон нутгийн өмчит ХХК, ОӨААТҮГ-ын 2019-2021 онуудын санхүүгийн үйл ажиллагааны үр ашгийн тооцоо, үр нөлөөг хэрхэн тооцсонд аудит хийхэд ХААХИ” ОНӨХХК, “Тэшиг ус” ОНӨААТҮГ, “Илчит хутаг” ОНӨААТҮГ-ууд нь 2019-2021 онуудад орлого, зардлын, ашиг алдагдлын тооцоог нэгтгэн гаргаж ажиллан үр нөлөө, үр дүнг нь тооцон ажилласан баримт материал байхгүй дутуу ТБӨӨ-ийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 3 дахь¹¹, 20 дугаар зүйлийн 7 дахь¹² гэсэн заалтыг хэрэгжүүлээгүй байна.

“Булган мээж” ОНӨХХК-ний хувьд 2019-2021 онуудад жил бүр үр ашиг, үүсэх эрсдэл, үр дүнг тооцсон байна. Үүнд: 2019 онд 7, 2020 онд 6, 2021 онд 6 асуудлуудыг тус бүр хэлэлцэж цаашид хэрэгжүүлж ажиллахаар тусгасан ажлаас нүхэн жорлонгийн, Булган сумын 9, 10, 14-р ус түгээх байрнуудыг ухаалаг төхөөрөмж суурилуулах ажил, цэвэрлэх байгууламжийн үйл ажиллагааны зардлыг тодотгол оруулах, аж ахуй нэгж болон орон сууцны айл өрхүүдийн тоолуур баталгаажуулах Ус дулаан дамжуулах төв доторх хэрэгцээний халуун усны тоног төхөөрөмжийн автоматжуулалтыг шалгаж, тохиргоог хийж, бэлтгэл ажлыг хангах зэрэг ажлууд хэрэгжсэн байна.

2.3.3. Харилцагч байгууллагуудтай гэрээ хийж ажиллаж байгаа ч үндэслэлгүйгээр гэрээний дүн, хувийг өөрчилж ажилласнаар 19.9 сая төгрөгийн үргүй зардал зарцуулсан байна.

Аймгийн хэмжээнд үйл ажиллагаагаа явуулж байгаа ОНӨХХК, ОНӨААТҮГ-ын гэрээ хийсэн баримт материалд аудит хийхэд “Тэшиг ус” ОНӨААТҮГ, “Илчит хутаг” ОНӨААТҮГ-ууд нь нүүрс нийлүүлэх гэрээг иргэн, ХХК-тай шууд гэрээ байгуулсан, тендер зарлаж сонгон шалгаруулалт хийж ажиллаагүй нь ТБӨӨХБАҮХА тухай хуулийн 7дугаар зүйлийн 1-д¹³, 7 дугаар зүйлийн 3-д¹⁴ заасан заалтуудыг тус тус хэрэгжүүлж ажиллаагүй байна.

“Илчит Хутаг” ОНӨААТҮГ-ын гүйцэтгэх захирал нь сумын Засаг даргатай 2019-2021 онуудад байгуулсан гэрээний хүрээнд сумын төвийн орон сууцны хангамж, ундны усаар бүрэн хангах, хог хаягдлыг цэвэрлэх, нэгдсэн хогийн цэгт хаях асуудлыг шийдвэрлэх, нохой устгал, ногоон хөгжил гэсэн 5 ажлын хүрээнд хийхээр гэрээ хийсэн боловч гэрээнд тусгагдаагүй сумын төвийн гэрэлтүүлгийн цахилгааны зардалд 2019-2021 онуудад нийт 7.9 сая төгрөгийг төлсөн нь холбогдох эрх зүйн акт байхгүй байгаа тул үүнд зөвлөмж хүргүүлээ.

Мөн “Сумын төвийн шинэчлэл” төсөл ЗГ-ын хөрөнгө оруулалтаар Хутаг-Өндөр суманд 2014-2015 онд хэрэгжиж гүйцэтгэгчээр “Эрхэт наран” ХХК, “Ану сервис” ХХК түншлэлийн гэрээтэйгээр тендерт шалгарч БНЧУ-д үйлдвэрлэгдсэн 647.3 сая төгрөгийг өртөгтэй, 0.6

¹¹ Үйлдвэрийн газрын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулан биелэлтийг хангах;

¹² “Тогтоосон журмын дагуу анхан шатны бүртгэлийг хөтөлж нягтлан бодох бүртгэлийн тайлан тэнцэл, статистикийн мэдээ гаргах ажлыг зохион байгуулж, тэдгээрийн үнэн зөвийг хариуцах

¹³ Захиалагч бараа, ажил, үйлчилгээ худалдан авахдаа дор дурдсан тендер шалгаруулалтын журмыг баримтлан гүйцэтгэгчийг сонгож гэрээ байгуулна

¹⁴ Захиалагч энэ хуулийн 8.1.2-т заасан босго үнээс бага төсөвт өртөгтэй бараа, ажил, үйлчилгээг энэ хуулийн 7.1 дэх хэсэгт заасан журмыг мөрдөхгүйгээр шууд худалдан авч болно

мВт халаалтын 2 ширхэг зуух, яндангийн хамт суурилуулсан боловч гар аргаар нүүрсийг буталж цэнэглэхэд хүндрэлтэй, зуух удаа дараа задарч засварт орж, олон бэрхшээл учирч байсан тул 2020 онд 2 зуухыг зогсоож, байгууллагын гадна талбайд ашиглахгүй байгаа нь хадгалалт хамгаалалтын горим хангахгүй, тухайн зуух, яндангийн элэгдэл тооцоогүй, 517.8 сая төгрөгийн үлдэх өртөгтэй 2021 оны жилийн эцэст тайлагнасан зөрчил илэрсэн тул албан шаардлага хүргүүлээ.

/ЭкоЭффект дулаан үйлдвэрлэлийн 647.3 сая төгрөгийн 2 ширхэг зуух/ Зураг-1



Цаашид “Илчит Хутаг” ОНӨААТҮГ-ны дарга нь дээрх зуухыг эрх бүхий этгээдээр үнэлгээ хийлгэж үнэ тогтоолгон үлдэх өртгийг бууруулан худалдан борлуулах хүсэлтэй байгаагаа танилцуулсан.

“ХААХИ” ОНӨХХК-ний хувьд чацаргана төсөл, тоног төхөөрөмжийн эргэн төлөлтийн гэрээг 2020 онд 16 сум, 1 тосгоны 900 гаруй иргэдтэй хийж, өмнөх 2021 онд хийгдсэн гүйцэтгэлийн аудитаар чацаргана суулгац, хашаа, усалгааны системийн 13.7, арьс элдэх 3 ширхэг тоног төхөөрөмжийн 25.5, жимс, ногоо хатаагч төхөөрөмжийн 5.4 сая төгрөгийн нийт 20 иргэнтэй 44.6 сая төгрөгийн гэрээ хийгээгүй зөрчилд албан шаардлага хүргүүлсний дагуу хэрэгжилтийг тооцон гэрээ хийж ажилласан байна.

“Булган мээж” ОНӨХХК-ий хувьд 2019-2021 онуудад аж ахуй нэгж, төсөвт байгууллага, иргэдтэй дулаан түгээх, нүүрс, материал нийлүүлэх, аудит хийлгэх, ажил гүйцэтгүүлэх зэрэг хийж ажилласан боловч тендерт шалгарсан иргэдээс нүүрс худалдан аваагүй, гэрээ хийхдээ нүүрс нийлүүлэх хугацаа тавигдаагүй, гэрээ хийсэн хугацааг 2022 оны 12 дугаар сарын 10-ны өдрөөр хийсэн зэрэг зөрчлүүд илэрсэнд зөвлөмж хүргүүлж ажиллалаа.

“Булган мээж” ОНӨХХК нь 2021 онд аймгийн төвийн гэр хорооллын 200 айл өрхөд боловсон, соруулдаг жорлон барих гэрээний төсөвт өртөг 184.5, Булган сумын тохижилт үйлчилгээний ангийн гадна шинээр хийх инженерийн шугам сүлжээний ажлын төсөвт өтрөг 80.5 сая төгрөгөөр тус тус гэрээ хийж, ажлыг гүйцэтгэн 242.4 сая төгрөгийг ашигтай ажилласан ч өмнөх 2019 онд “Энержи плас” ХХК-тай дулааны эрчим хүч худалдах, худалдан авах гэрээг аймгийн Засаг даргаар батлуулан, 2019 оны 09 дүгээр сарын 15-ны өдрийн 100 тоот дугаартай гэрээнд хэрэглэгчдэд борлуулсан дулааны орлогыг 60 хувийг Б тал буюу “Энержи плас” ХХК-д, 40 хувийг буюу А тал буюу “Булган мээж” ХХК-д дулааны орлого байхаар гэрээ хийсэн байсныг 2019 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн 3 тоот дулааны эрчим хүч худалдах, худалдан авч хамтран ажиллах гэрээ хийж тус гэрээнд дулааны борлуулалтын орлогын 70 хувийг Б тал буюу “Энержи плас” ХХК-д 30 хувийг А тал буюу “Булган мээж” ОНӨХХК-ний дулааны орлого байхаар гэрээ хийсэн нь өмнөх

гэрээг хүчингүй болгосон тогтоол шийдвэр гараагүй байхад байгууллагын дарга “Энержи плас” ХХК-ий захиралтай гэрээ хийсэн, гэрээ хийхдээ дулааны үнэ тарифт өөрчлөлт оруулалгүй “Булган мээж” ОНӨХХК нь тус компанитай гэрээ хийж 2.7 тэрбум төгрөгийн алдагдалд орсноор өмгөөлөгч авч ажиллуулсны хөлсөнд 12.0 сая төгрөгийг зарцуулжээ.

Уг асуудлын хүрээнд Энержи плас ХХК нь 2.7 сая төгрөгийн дулааны мөнгөний дутуу Булган мээж ОНӨХХК-иар төлүүлэхээр шүүхэд хандсаны дагуу өмгөөлөгч авч ажилласны дагуу 2022 оны 04 сарын 07 өдрийн 132/ШЗ2022/00781 тоот “Хэргийг хэрэгсэхгүй болгох тухай” шүүх захирамжид “Иргэний хэрэг шийдвэрлэх тухай хуулийн 65 дугаар зүйлийн 65.1.3-д заасан үндэслэл тогтоогдож байгаа тул “Энержи плас” ХХК –ийн нэхэмжлэлд 3.2 тэрбум төгрөг гаргуулах тухай нэхэмжлэлийн шаардлага бүхий 132/2021/00690/И дугаарын индекстэй иргэний хэргийг хэрэгсэхгүй болгосугай” гэсэн захирамж гарчээ.

Энэ нь 2013 онд тогтоосон дулааны үнэ тарифаар хэрэглэгчдээс 330 төгрөгөөр 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр хүртэл үнээ өсгөөгүй, гэрээгээ өөрчлөөгүй байхад 2019 онд Энержи пластай 1г/дж дулааныг 34360.3 төгрөгийн 1м3 талбай хэмжээний дулааны үнийг шилжүүлэхэд дунджаар 1500 төгрөг буюу 1170 төгрөгийн илүүтэйгээр дулааны үнэ нэмж өгөхөөр гэрээ хийсэн нь алдагдалтай ажиллахад нөлөөлсөн байна.

Мөн “Булган мээж” ОНӨХХК нь ЭХЗХ-ны 2021 оны 10 дугаар сарын 14-ний өдрийн 459 тоот “Тариф батлах тухай” тогтоолыг үндэслэж 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангаар 42 төсөвт байгууллагаас 283.5 сая төгрөгийн авлагыг 182.3 сая төгрөгөөр нэмэгдүүлж нийт 465.8 сая төгрөгийн авлагатайгаар тайлагнасан нь байгууллага, албан газруудтай тухайн онд дулаан нийлүүлэх гэрээг шинэчилж хийгээгүй, нэмж тусгасан дүнгээр тооцоо нийлж баталгаажуулан ажиллаагүй, аймгийн Засаг даргын 2021 оны 122 дугаар сарын 22-ны өдрийн 01/1458 тоот албан бичиг, СТСХ-ийн даргын 2022 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн 06/02 тоот “Зөвлөмж хүргүүлэх тухай” албан бичгүүдийг дагаж мөрдөөгүй, үнийн зөрүү болох 182.3 сая төгрөгийн авлагыг нэмэгдүүлснээр тайланд тусгасан зөрчил илэрсэнд аудитаар албан шаардлага хүргүүлжээ.

2.4. Орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой хуулийн этгээдийн санхүүгийн үйл ажиллагаа, зардал үр ашгийн зохистой харьцааг хангаагүй, сүүлийн 3 жилийн дунджаар төлөвлөснөөсөө илүү зарцуулалт хийгдсэн байна.

2.4.1. Удирдлагын зардлыг төлөвлөж байгаа ч зарим газрууд нь зардлыг төлөвлөж батлуулдаггүй, 2019-2021 онуудад 118.2 сая төгрөгийг илүү зарцуулжээ.

Төрийн болон орон өмчит, өмчийн оролцоотой хуулийн этгээдүүд нь жилийн төсвийн задаргаанд удирдлагын зардлыг тусад нь төлөвлөж батлуулсан боловч “Илчит хутаг” ОНӨААТҮГ нь 2019, 2021 онуудад, “ХААХИ” ОНӨХХК нь 2019-2021 онуудад удирдлагын зардлыг тус тус төлөвлөж ажиллаагүй нь Компаний тухай хуулийн 65 дугаар зүйлийн 6-гийн 6.¹⁵ Заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Тус байгууллагуудын удирдлагын зардлын төлөвлөлт гүйцэтгэлийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт-3		сая/төг								
		2019 он			2020 он			2021 он		
№	Байгууллагын төрөл	төлөвлөлт	гүйцэтгэл	Хэтрэлт, хэмнэлт	төлөвлөлт	гүйцэтгэл	Хэтрэлт, хэмнэлт	төлөвлөлт	гүйцэтгэл	Хэтрэлт, хэмнэлт
1	“Булган мээж” ХХК	335.0	333.8	-1.2	310.6	365.7	55.1	405.3	356.4	-48.9
2	“Тэшиг ус” ОНӨААТҮГ				2.3	2.3	0	1.0	1.0	0
3	“Илчит хутаг” ОНӨААТҮГ	0	0	0	27.4	27.4	0	0	63.1	63.1
4	“ХААХИ” ОНӨХХК	0	0	0	0	0	0	0	0	0

¹⁵ компанийн төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлагын зардал, цалин, урамшуулал

Дээрхээс үзэхэд: “Илчит хутаг” ОНӨААТҮГ нь 2019, 2021 онд удирдлагын зардлыг төлөвлөөгүй боловч 2021 онд удирдлагын зардалд 63.1, “Булган мээж” ХХК нь 2020 онд 55.1 сая төгрөгийг тус тус хэтрүүлэн зарцуулжээ.

Дээрх байгууллагуудын удирдлагын зардлын гүйцэтгэлийг анхан шатны баримттай тулгахад “Тэшиг ус” ОНӨААТҮГ нь 2020 онд 3 ахмаддаа байгууллагын дотоод журмын 14.2.1-д¹⁶ гэсэн заалтыг үндэслэж 300.0 мянган төгрөгийн тэтгэмж олгосон нь хамраалгүй заалтаар тушаал гарган зарцуулсан зөрчилд аудитаар албан шаардлага хүргүүлжээ.

2021 онд байгууллагын удирдлага нь ажилчдад олгох түлээ нүүрсний хөнгөлөлтийн хавсралтад нэрээ оруулан 210.0 мянган төгрөгийн түлээ, нүүрсний тэтгэмж авсан, томилолтын зардал олгосон ажилчид түншлэлийн зардлаас 108.8 мянган төгрөгийн хүнс бэлтгэсэн зөрчилд аудитаар төлбөрийн акт хүргүүлжээ.

Мөн “Булган мээж” ОНӨХХК нь удирдлагын зардалд ТУЗ-ийн дарга болон гишүүдийн цалин, урамшууллыг төлөвлөж ажиллаж байгаа ч ТУЗ-ийн ажлын тайлан мэдээ гаргаж ажиллаагүй, улирал, жилд хуралдах хуралдаанд ирсэн ирцээр цалин урамшуулал олгосон нь ТУЗ компаний дотоод дүрмийн 6.2 дахь¹⁷ гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүйд аудитаар зөвлөмж хүргүүлжээ.

Цаашид удирдлагын зардал төлөвлөж ажиллаагүй газруудад ирэх оны төсвийн зардлыг төлөвлөхдөө удирдлагын зардлыг тооцоолон төлөвлөж батлуулж ажиллах шаардлагатай байна.

2.4.2. Үйл ажиллагааны зардлыг бодиттой төлөвлөж ажиллаагүйгээс 2019-2021 онуудад 2252.8 сая төгрөгийн илүү зарцуулалттай, 227.0 сая төгрөгийн хэмнэлттэй ажилласан үзүүлэлтэй гарч байна.

“Булган мээж” ОНӨХХК, “Тэшиг ус” ХХК, “Илчит хутаг” ОНӨААТҮГ, “ХААХИ” ОНӨХХК-ын 2019-2021 онуудын санхүүгийн үйл ажиллагааны зардлыг төлөвлөгөө, гүйцэтгэлийг авч үзвэл ихэнх байгууллага нь илүү зарцуулалттай байна.

Үүнийг байгууллага тус бүрээр нь хүснэгтээр харуулбал:

Хүснэгт-4		/сая.төг/								
№	Байгууллагын төрөл	2019 оны зардал			2020 оны зардал			2021 оны зардал		
		төлөвлөгөө	гүйцэтгэл	Хэмнэлт хэтрэлт	төлөвлөгөө	гүйцэтгэл	Хэмнэлт хэтрэлт	төлөвлөгөө	гүйцэтгэл	Хэмнэлт хэтрэлт
1	“Булган мээж” ХХК	3522.6	4394.5	871.8	4779.9	6056.1	1276.2	7001.7	6912.2	-89.5
2	“ХААХИ” ХХК	0	0	0	78.9	85.1	6.2	128.1	143.9	15.8
3	“Тэшиг ус” ОНӨААТҮГ	291.1	217.6	-73.5	318.8	307.7	-11.1	374.2	387.9	13.7
4	“Илчит хутаг” ОНӨААТҮГ	544.4	491.5	-52.9	510.8	537.2	26.4	552.9	609.3	56.4

Дээрх хүснэгтээс үзэхэд “Булган мээж” ОНӨХХК, “ХААХИ” ОНӨХХК, “Илчит хутаг” ОНӨААТҮГ-ууд нь 2019, 2020, 2021 онуудад нийт 2252.8 сая төгрөгийн илүү, 227.0 сая төгрөгийн хэмнэлт үүссэн байна.

Үүнээс: “ХААХИ” ОНӨХХК нь шинэ хөдөө төслөөр хэрэгжсэн жимс, жимсгэнэ, тоног төхөөрөмжийн эргэн төлөлтийн орлогоос 2020 онд хадлангийн зардалд 6.2, 2021 онд Ланд-100 маркийн автомашин худалдан авах зардалд 15.8 сая төгрөгийг тус тус зарцуулжээ.

Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа ОНӨХХК, ОНӨААТҮГ-уудын 2019-2021 онуудын орлого, зарлага, зарлагын гүйцэтгэл, алдангийн үзүүлэлтийг хүснэгтээр харуулбал:

¹⁶Өндөр настны тэтгэвэрт гарч буй хүмүүст Монгол улсын тэтгэвэр тэтгэмжийн тухай хуулийн дагуу хүндэтгэл үзүүлж, дурсгалын бичигтэй дунд гарын мөнгөн аяга гардуулна.

¹⁷Төлөөлөн удирдах зөвлөл нь үйл ажиллагааныхаа тайланг жилд 2-оос доошгүй удаа, компаний ашгийн хуваарилалтын талаарх саналыг болосруулж дараа оны 01 дүгээр улиралд багтаан үүсгэн байгуулагчийн хэрлээр хэлэлцүүлнэ

Төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой хуулийн этгээдийн үйл ажиллагааны үр ашиг

Хүснэгт-5											/сая.төг/		
№	Байгууллагын нэрс	Орлогын Төлөвлөгөө			Орлогын гүйцэтгэл			Зардлын гүйцэтгэл			Алдагдал		
		2019	2020	2021	2019	2020	2021	2019	2020	2021	2019	2020	2021
1	"Булган мээж" ХХК	4143.8	4200.4	4925	4744	4362	4067	3866	4603.1	6582.7	277.6	-579.5	-1808.2
2	"Тэшиг ус" ОНӨААТҮГ	283.7	319.8	381.4	198.9	309.8	397.8	291.1	318.9	374.2	-7.4	1	7.2
3	"Илчит хутаг" ОНӨААТҮГ	577	541.5	615.9	543.8	574.1	630.3	541.5	510.8	552.9	2.3	2.9	25.1
4	"ХААХИ" ОНӨХХК	0	222.8	195.8	0	96.8	158.6	0	72.9	128.1	0	10.6	13.2
	Нийт дүн	5004.5	5284.5	6118	5486	5343	5253	4699	5505.7	7637.9	272.5	-565	-1762.7

Дээрх хүснэгтээс үзэхэд 3 жилийн дунджаар "Илчит хутаг" ОНӨААТҮГ нь алдагдалтай ажиллаагүйгээр, бусад газрууд нь зарим жилд алдагдалтай ажилласнаар илэрхийлэгдэж байна.

Тус ОНӨХХК, ОНӨААТҮГ-уудын 2019-2021 онуудын зардлын гүйцэтгэлийг анхан шатны баримттай тулгахад томилолтын зардлыг илүү тооцсон, ашиглаж байгаа автомашины спидометрийн заалтын хэрэгсэл эвдэрсэн, авлага, өглөг дутуу тусгасан, авлагыг барагдуулж ажиллаагүй, хүнсний материалыг аж ахуйд бүртгэж тайлагнасан, бэлэн мөнгөний тайланд орлого авч тайлагнаагүй, анхан шатны баримтын бүрдэл дутуу, ТУЗ-ийн тогтоол шийдвэргүйгээр автомашины ашиглах гэрээ хийсэн, ажилчдын НДШ-ын зардлыг дутуу зэрэг зөрчлүүд илэрлээ.

Тухайлбал: "Булган мээж" ОНӨХХК нь ажилчдад томилолтын зардал тооцохдоо 344.0 мянган төгрөгөөр илүү олгосон зөрчилд төлбөрийн акт, БУА- 03-30, 63-68 дугаартай автомашинуудын 2021 оны 54.0 сая төгрөгийн шатахуун, явсан км-ийг нормын дагуу зарцуулсныг шалгахад 57.8 сая төгрөгөөр илүү зарцуулснаар тайлагнасан, километрийн заалтын хэрэгсэл эвдэрсэн, жолоочийн тооцооны замын хуудас хөтлөлт, километрийн заалт бичигдсэн нь тодорхой бус, байгууллагын даргын 2021 оны А/64, А/65 тоот тушаалаар тэтгэвэрт гарч байгаа 2 ажилтанд 10000.0, 20000.0 мянган төгрөгийн тэтгэмж тус тус олгохоос нийт 15000.0 мянган төгрөгийг олгож 15000.0 мянган төгрөгийг өглөгөөр тусгаж тайлагнаагүй, 2022 онд 5000.0 мянган төгрөгийн тэтгэмж олгосон зөрчилд аудитаар албан шаардлага тус тус бичлээ.

Мөн 2021 оны бэлэн мөнгөний гүйлгээ, тайланг шалгахад нярвын дансанд шилжүүлсэн 2719.3 төгрөгийг бэлэн мөнгөний орлогын тайланд тусгаагүй, 500.0 мянган төгрөгийн шагнал олгосон АШБ-ууд дутуу, хүнсний материалын 9646.3 мянган төгрөгийн орлогыг аж ахуйн материалын дансанд орлого авч тайлагнасан зөрчлүүдэд зөвлөмж хүргүүлээ.

"Тэшиг ус" ОНӨААТҮГ нь 2021 онд ТУЗ-ийн тушаал, шийдвэргүйгээр автомашин ашиглах гэрээ байгуулж тус автомашины засвар үйлчилгээнд 1070.0 мянган төгрөгийг зарцуулсан, анхан шатны баримтын бүрдэл нь дутуу, дугуйны худалдаа хийдэггүй газрын зарлагын баримт хавсаргасан зэрэг зөрчил илэрсэн нь НББ-ийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 1-д¹⁸, 13 дугаар зүйлийн 6-д¹⁹, байгууллагын дүрмийн 5 дугаар зүйлийн 8-д²⁰ гэсэн заалтуудыг хэрэгжүүлж ажиллаагүйд албан шаардлага хүргүүлсэн.

¹⁸ Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно.

¹⁹ Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна.

²⁰ Газрын үйл ажиллагааг хэвийн аюулгүй явуулахад зайлшгүй хэрэгцээ шаардлагатай хөрөнгийг батлан шийдвэрлэнэ.

Төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой хуулийн этгээдийн үйл ажиллагааны үр ашиг

“ХААХИ” ОНӨХХК нь 2021 оны иргэдийн эргэн төлөлтийн 28.4 сая төгрөгийн авлагыг барагдуулж ажиллаагүй, мөн байгууллагын дотоод журмыг 2021 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн ТУЗ-ийн 08 дугаар тогтоолоор шинэчилж ажилласан боловч өмнөх дотоод журмын заалтыг үндэслэж 2 ажилтанд 880.0 мянган төгрөгийн урамшуулал олгосон зөрчилд төлбөрийн акт, авлага барагдуулж ажиллахаар албан шаардлага хүргүүлж ажиллалаа.

Авлагын үлдэгдлийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт-5				/төгрөгөөр/
№	Сум	Дутуу төслөн иргэн	Дүн	Тайлбар
1	Баян-Агт /2019-2021 он/	2	5988850	Арьс нэхий элдэх төхөөрөмж, трактор агрегатын төлөлт дутуу
2	Баяннуур /2019-2021 он	2	4801460	Трактор агрегатын төлбөр дутуу
3	Бугат /2020-2021 он/	0	-1500	2021 оны төлөлт бүрэн хийгдсэн.
4	Булган /2020-2021 он/	11	3630500	Хүлэмж, хонины ноос хяргах төхөөрөмжийн эргэн төлөлт дутуу хийгдсэн.
5	Бүрэгхангай /2019-2021 он	2	1470000	Арьс нэхий элдэх төхөөрөмж, трактор агрегатын төлөлт дутуу
6	Гурванбулаг /2019-2021 он/	1	620000	Арьс нэхий элдэх төхөөрөмжийн эргэн төлөлт хийгдсэн
7	Дашинчилэн /2019-2021 он/	4	2841710	Хүлэмж, арьс нэхий элдэх төхөөрөмж, трактор агрегатын эргэн төлөлт дутуу хийгдсэн.
8	Могод /2020-2021 он/	3	1780000	Хүлэмж, трактор агрегатын төлөлт дутуу
9	Орхон /2019-2021 он/	2	-2491100	Трактор, агрегатын эргэн төлөлт илүү төлөлттэй.
10	Рашаант /2019-2021 он/	0	-1880000	Трактор, агрегат, хүлэмжний түлээсийн илүү төлөлттэй
11	Сайхан /2020-2021 он/	6	2874000	Арьс нэхий элдэх төхөөрөмж, айраг хадгалах хөргүүрт чингэлэг, хүлэмжийн эргэн төлөлт дутуу.
12	Сэлэнгэ /2020-2021 он/	3	-2375000	Хадлангийн салаа, хүлэмж илүү төлөлттэй.
13	Тэшиг /2019-2021 он/	2	2000000	Арьс нэхий элдэх төхөөрөмж, трактор агрегатын эргэн төлөлт дутуу хийгдсэн.
14	Хангал /2019-2021 он/	3	5480500	Трактор, хадлангийн тоног төхөөрөмжийн төлөлт дутуу.
15	Хишиг-Өндөр /2019-2021 он/	2	2550000	Арьс нэхий элдэх төхөөрөмж, хонины ноос хяргах төхөөрөмжийн эргэн төлөлт дутуу
16	Хутаг-Өндөр /2019-2021 он/	5	-452700	Хадлангийн салаа, хүлэмж илүү төлөлттэй.
17	Хялганат /2019-2021 он/	2	1599250	Арьс нэхий элдэх төхөөрөмж, хүлэмжийн эргэн төлөлт дутуу.
Нийт дүн		50	28,435,970	

2.4.3. Шаардлагатай хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг зарим онуудад ОНӨААТҮГ-ууд төлөвлөж ажиллаагүй байна.

Аймаг суманд үйл ажиллагаа явуулж байгаа ОНӨХХК, ОӨНААТҮГ-ын 2019-2021 онуудын хөрөнгө оруулалт төлөвлөгөөг үзэхэд “Илчит хутаг” ОНӨААТҮГ 2019-2021 онуудын, “ХААХИ” ОНӨААТҮГ нь 2021 оны, “Тэшиг ус” ОНӨААТҮГ нь 2021 оны шаардлагатай хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг тус тус боловсруулж ажиллаагүй байна.

“ХААХИ” ОНӨААТҮГ нь 2021 онд төл сонгино үрлэгчийг 8.3, “Тэшиг ус” ОНӨААТҮГ нь 2021 онд 2.3 сая төгрөгийн зөөврийн компьютер тус тус худалдан авсан байна.

Хөрөнгө оруулалтын төлөвлөгөө боловсруулан ажилласан газруудыг дурдвал:

“Булган мээж” ОНӨХХК 2019-2021 онуудад 110.4 сая төгрөгийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг ТУЗ-ийн 2020 оны 06, 09 дүгээр тогтоолоор, “ХААХИ” ОНӨХХК нь 2020 оны ТУЗ-ийн 06 дугаар тогтоолоор 6.2, 2021 оны ТУЗ-ийн 13 дугаар тогтоолоор 22.5 сая төгрөгийн тавилга, тоног төхөөрөмжийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг тус тус төлөвлөн батлуулж ажиллажээ.

3. Орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой хуулийн этгээдийн хяналт үр нөлөө бага байна.

3.1. Санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн хөндлөнгийн хяналт үр нөлөө үзүүлснээр илэрхийлэгдэж байгаа ч үйл ажиллагаанд нь хийсэн хяналт хангалтгүй үзүүлэлтэй байна.

3.1.1. Орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой хуулийн хуулийн этгээдийн үйл ажиллагаанд төрийн байгууллагуудад хяналт шалгалт хийсэн боловч хяналт шалгалтын материалыг хүргүүлж ажиллаагүй байна.

Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа ОНӨХХК, ОНӨААТҮГ-уудад 2019-2021 онуудын үйл ажиллагаанд нь хяналт шалгалт хийсэн ч баримтжуулдаггүй, зарим сумдын ИТХ болон ЗДТГ-аас хяналт шалгалт хийгээгүй байна.

Тухайлбал: “Булган мээж” ОНӨХХК-ий 2019-2020 онуудад 2 удаа байгууллагын үйл ажиллагаа болон “Энержи плас” ХХК-тай хийсэн дулааны гэрээ, нөхцөл, өр авлагын талаар хэлэлцэж, амаар заавар зөвлөгөө өгч ажилласан гэх боловч шалгалтын материалыг баримтжуулан хүргүүлж ажиллаагүй байна.

“ХААХИ” ОНӨХХК, “Илчит хутаг” ОНӨААТҮГ, “Тэшиг ус” ОНӨААТҮГ-уудын сумдын ИТХ, ЗДТГ-аас үйл ажиллагаатай нь холбоотой хяналт шалгалт хийгдээгүй нь ТБОНӨ-ийн тухай хуулийн 77.2.2²¹, 78.2.1²² гэсэн заалтыг мөрдлөг болгож ажиллаагүй байна.

3.1.2. Төрийн өмчит хуулийн этгээдийн санхүүгийн үйл ажиллагаанд тавих төрийн байгууллагуудын хяналт үр нөлөөтэй байна.

“Булган мээж” ОНӨХХК, “ХААХИ” ОНӨХХК, “Илчит хутаг” ОНӨААТҮГ, “Тэшиг ус” ОНӨААТҮГ-ад 2019-2021 онуудад Төрийн аудитын газар, Санхүү хяналт, аудитын алба нь 2019 оны үйл ажиллагаанд хяналт шалгалтыг хийснээр хүний нөөц, худалдан авах, нүүрсний гэрээ, бэлэн мөнгөний гүйлгээ, авлага өглөгийг багасгах тал дээр арга хэмжээ авч шийдвэрлэх талаар зөвлөмж өгч ажилласнаар зарим газрын өр, авлага болон өмнөх алдаа зөрчил багассан үзүүлэлтэй байна.

Үүнд: “Тэшиг ус” ОНӨААТҮГ-т хяналт шалгалт хийснээр бэлэн мөнгөний гүйлгээ багассан, өглөг өмнөх оноос 51444.2 мянган төгрөгөөр буюу 64 хувиар буурсан, 43189.1 мянган төгрөгийн ашигтай ажилласан нь алдаа зөрчил багассан үзүүлэлтэй илэрхийлэгдэж байна.

“Булган мээж” ОНӨХХК-ий хувьд 2019 онд төрийн аудитын байгууллага, Санхүү хяналт, аудитын албаас хяналт шалгалт хийгдсэнээр бэлэн мөнгөний гүйлгээ, НДШ-ийн тооцооллын алдаа, бүртгэл тайлагнал, жолоочийн тооцооны замын хуудас, бүртгэл, хөтлөлт, нүүрсний тооцоолол, автомашины дотор зэрэг алдаа зөрчил нь давтагдаагүй багассан байна.

“Шинэ хөдөө-Хөгжил” ОНӨААТҮГ-ын 2020 онд санхүүгийн тайлангийн аудитаар 2 албан шаардлага, 9 зөвлөмж нийт 11 зөрчил илэрч хязгаарлалттай дүгнэлтийг авч, 2021 онд аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2021 оны 09-р сарын 05-ны өдрийн 54 тоот тогтоолоор “Хөдөө аж ахуй-хөгжлийн ирээдүй” ОНӨХХК болж нэрээ өөрчилж санхүүгийн тайлангийн аудитаар нийт 14 зөрчил илэрснээс 3 төлбөрийн акт, 8 албан шаардлага, 3 зөвлөмжийг өгч нийт 75.3 сая төгрөгийн алдаа зөрчил илэрч хязгаарлалттай дүгнэлт өгсөн, өмнөх оны алдаа зөрчилтэй харьцуулбал тээвэр шатахуун, анхан шатны баримтын бүрдэл, шилэн данстай холбоотой зөрчил давтагдан гарч байна.

Мөн 2021 оны гүйцэтгэлийн аудитаар сумдад олгосон 206.5 сая төгрөгийн тоног төхөөрөмжийг эзэнжүүлээгүй, 4 иргэнд 35 бүлийн 22.7 сая төгрөгийн зөгий, 8.3 сая төгрөгийн 3 бух үхсэн нь малын эмчийн тодорхойлолтгүй, чацаргана, хашаа авсан 44.6

²¹ иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчид, Засаг даргаас орон нутгийн өмчийн хөрөнгийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхээ хэрэгжүүлэх талаар зохиосон ажил, үр ашгийн тайлан, нэгдсэн тооллогын дүнг жил бүр хэлэлцэж, дүгнэлт, чиглэл өгөх

²² иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас олгосон эрх хэмжээний дотор орон нутгийн өмчийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах

сая төгрөгийн гэрээ байгуулаагүй, үндсэн хөрөнгийг орлого дутуу, үр дүнг тооцож ажиллаагүй 218.0, 2.1 төгрөгийн бэлэн мөнгөний орлого дутуу, цалинг илүү дутуу олгосон, анхан шатны баримт дутуу нийт 502.2 сая төгрөгийн зөрчилд 7 зөвлөмж, 10 албан шаардлага, 6 төлбөрийн акт хүргүүлж ажилласнаас хэрэгжилт нь 442.6 сая төгрөг буюу 88 хувьтай хэрэгжсэн байна.

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2020 оны 05 сарын 20-ны өдрийн 41 дүгээр тогтоолоор 2017-2019 онуудад “Шинэ хөдөө-Булган” дэд хөтөлбөрийн хүрээнд Улсын болон байгаль хамгаалах сангийн хөрөнгө оруулалтаар бий болсон 3.7 тэрбум төгрөгийн хөрөнгийг “Шинэ хөдөө-Хөгжил” ОНӨААТҮГ, сумдын данс бүртгэлд тусгуулах, төрийн өмчид шилжүүлэх, ажлаар аймгийн ЗДТГ-аас комисс гарган ажлын хэсэг ажиллахад хөрөнгө дутсан шалтгаанаар цагдаагийн байгууллагад шилжүүлсэн боловч уг асуудалд АТГ-т шилжигдэн одоог хүртэл шалгагдаж шийдвэрлэгдээгүй байна.

3.2. Дотоод хяналтын тогтолцоо оновчгүй, хяналт үр нөлөө үзүүлж ажиллаагүйгээр илэрхийлэгдэж байна.

3.2.1. ОНӨХХК, ОНӨААТҮГ-ууд нь ТУЗ-ын дэргэдэх хороо байгуулаагүй болно.

“Булган мээж” ОНӨХХК, ХААХИ ОНӨХХК, “Тэшиг ус” ОНӨААТҮГ, “Илчит хутаг” ОНӨААТҮГ-ууд нь ТУЗ-ийн дэргэдэх хороогүй болно.

3.2.2. Аймагт үйл ажиллагаагаа явуулж байгаа ХХК, болон ОНӨААТҮГ-ын дотоод хяналтын ажилтан нь дотоод хяналт хийсэн гэх боловч хангалтгүй байна.

“Булган мээж” ОНӨХХК, “Тэшиг ус” ОНӨААТҮГ нь дотоод хяналтын ажилтантай, “ХААХИ” ОНӨХХК, “Илчит хутаг” ОНӨААТҮГ-ууд нь дотоод хяналтын ажилтангүй байна.

Тухайлбал: “Булган мээж” ОНӨХХК нь дотоод хяналт хуулийн зөвлөх, хүний нөөцийн ажилтны орон тоог 2021 онд дотоод хяналт хуулийн зөвлөх гэж орон тоо нэмж батлан ажиллуулсан байна.

Тус ажилтны ажлын байрны тодорхойлолтод дотоод хяналт хуулийн зөвлөх ажилтны ажлын байрны тодорхойлолтод байгууллагын хэмжээнд төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус, гүйцэтгэлийн хяналт, шалгалтыг зохион байгуулж ажиллана гэж заасны дагуу ажиллаагүй, дотоод хяналтын шалгалтыг 2021 оны 06 сард нэг удаа дулааны төлбөрийн талаар “Энержи плас” ХХК-тай гэрээ хийсэн үйл ажиллагаанд шалгалт орсноос өөр шалгалт хийгдсэн тайлан мэдээ байхгүй байна.

“Тэшиг ус” ОНӨААТҮГ-ын дотоод хяналт хариуцсан ажилтан нь ажлын төлөвлөгөөт жилдээ 16-24 асуудлаар төлөвлөж биелэлтийг тооцож ажилладаг ч хяналт шалгалтаар гарсан алдаа зөрчилд үүрэг даалгавар өгч ажиллаагүй, сүүлийн 2 жилд ТУЗ-өөс хяналт шалгалт хийгдээгүй, нь байгууллагын дүрмийн 5.8-д²³ гэсэн заалтыг мөрдлөг болгож ажиллаагүй байна.

3.3. Мэдээллийн иж бүрэн, үнэн зөв, ил тод байдлыг хангаж байна уу?

3.3.1. Төрийн байгууллагуудын мэдээлэл уялдаатай байна.

Аймгийн ИТХ жил бүрийн ажлын төлөвлөгөөндөө тухайн жилийн 03 дугаар сард ОНӨХХК, ОНӨААТҮГ-уудын үйл ажиллагааны тайлантай танилцаж ажиллахаар төлөвлөн 2019 оны 01, 2020 оны 01, 2021 оны 01 дүгээр тогтоолын хавсралтаар тус тус батлан ажилласнаар аймгийн хэмжээнд үйл ажиллагаагаа явуулж байгаа ОНӨХХК, ОНӨААТҮГ-ууд байгууллагын дүрэмд заасны дагуу жилийн эцсийн үйл ажиллагааны тайланг ТУЗ болон аймаг, сумын ИТХ-д тэргүүлэгчдэд тайлагнадаг байна.

Мөн байгууллагууд нь тус бүр өөрийн байгууллагын цахим хуудсанд үйл ажиллагааныхаа тайланг мэдээлж ажилласан байна.

3.3.2. Төрийн өмчийн хуулийн этгээдийн мэдээлэл ил тод, нээлттэй байна.

²³ Зөвлөлийн хурал болон даргын гаргасан тогтоол, шийдвэр, зөвлөмж, үүрэг даалгаварын биелэлтийг хангуулж ажиллах

Мэдээллийн ил тод байдлыг Шилэн дансны тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2²⁴-д заасны дагуу байгууллагын мэдээллийн ил тод байдлыг ханган ажиллажээ.

Тухайлбал: “Илчит хутаг” ОНӨААТҮГ нь долоо хоног бүрийн мягмар гариг бүр удирдах ажилтны хуралдаанаар байгууллагуудтай тохижилт үйлчилгээний болон үйл ажиллагааныхаа талаар мэдээллээ солилцож ажилласан байна.

Мөн бусад байгууллагууд нь мэдээллийн ил тод байдлыг мэдээллийн самбар болон байгууллагынхаа facebook хаяг болон цахим хуудсаар мэдээллийг иргэдэд хүргэн ажиллажээ.

Дээрх байгууллагуудын шилэн дансны мэдээллийг өмнөх онуудын мэдээлснээс үзэхэд хугацаанд нь мэдээлдэггүй, хугацаа хоцроож мэдээлсэн нийтлэг алдаа илэрч байсан байна.

Гүйцэтгэлийн аудитын явцад 2022 оны эхний 5 сарын байдлаар мэдээлсэн мэдээг үзэхэд мэдээлэх мэдээллүүдийг хугацаанд нь мэдээлэн ажиллажээ.

ДҮГНЭЛТ:

Аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг гаргаж байна.

- “Булган мээж” ОНӨХХК, “ХААХИ” ОНӨААТҮГ, “Илчит хутаг” ОНӨААТҮГ, “Тэшиг ус” ОНӨААТҮГ-ийн ТУЗ-ийн гишүүд компаний засаглалын сургалтад бүрэн хамрагдаагүй байна.
- ТУЗ нь компаний засаглалыг үнэлэх аргачлал боловсруулж ажиллаагүй байна.
- ТУЗ-ийн дарга, гишүүд нь компаний засаглалын сургалтад хамрагдаж гэрчилгээ аваагүй байна.
- Аймгийн Засаг даргын 2016-2020 онд хэрэгжүүлэх мөрийн хөтөлбөр боловсруулахдаа Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн төрийн болон орон нутгийн өмчийн засаглал, өмч хувьчлалын бодлогыг сайжруулах зорилтыг төлөвлөж тусгаж ажиллаагүй тусгаагүй байна.
- Аймгийн Засаг даргын 2020-2024 онд хэрэгжүүлэх мөрийн хөтөлбөр боловсруулахдаа Засаг даргын 2020-2024 оны мөрийн хөтөлбөрт төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл, ашиглалт, хамгаалалтыг сайжруулах, холбогдох журам заавраар сургалт өгөхөөр 3 асуудал төлөвлөж ажиллажээ.
- ТУЗ-ийн тогтоол, шийдвэр үр нөлөө бага, зөвхөн жилийн төсөв, хөрөнгө бэлтгэх талаарх асуудлыг шийдэж ажиллажээ.
- Төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой хуулийн этгээдийн үйл ажиллагаа үр ашгийн төлөвлөгөөг зарим жил алдагдалтай төлөвлөж хянаж батлуулжээ.
- ОНӨХХК, ОНӨААТҮГ-уудын эрх бүхий этгээдүүд эдийн засгийн зорилтот түвшин, орлого, зарлага, ашиг алдагдалтай танилцаж ажилласан ч зарим байгууллага нь зардлыг дутуу, зарим нь алдагдалтай төсөв төлөвлөж батлуулсан байна.
- Төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой хуулийн этгээдүүд төлөвлөсөн орлогоо бүрэн бүрдүүлж ажилласан ч өмнөх оны төлбөрийн актыг байгууллагын орлогоос 490.0 мянган төгрөгийг барагдуулсан.
- Төлбөр, хураамжийг зардлыг зарим ОНӨААТҮГ нь төлөвлөж ажиллаагүй, 2019-2020 онуудад татварт төлсөн гүйцэтгэлээр 3649.8 сая төгрөгийг төвлөрүүлж ажиллажээ.
- ХХОАТ болох 207.1 мянган төгрөгийн татварын суутган тооцоогүй.
- Санхүүгийн үйл ажиллагаанд үр ашгийн тооцоо, шинжилгээг бодитой хийгээгүй, зарим зардлыг дутуу төлөвлөж, алдагдалтай ажиллахаар үр ашгийн тооцоо хийсэн байна.

²⁴ Энэ хуулийг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор шилэн дансны нэгдсэн цахим хуудастай байна. Шилэн дансны нэгдсэн цахим хуудас ажиллуулж эхлэх хугацааг энэ хуулийн хэрэгжилтийн байдлыг харгалзан Засгийн газар 2016 оны 06 дугаар сарын 30-ны өдрөөс өмнө байхаар тогтоох бөгөөд уг нэгдсэн цахим хуудсыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага эрхлэн хөтөлнө.

- Санхүүгийн үйл ажиллагааны үр ашгийн тооцоо, шинжилгээний үр нөлөөг “Булган мээж” ХХК-иас бусад ОНӨХХК, ОНӨААТҮГ-ууд дүгнэж ажиллаагүй байна.
- Ажил гүйцэтгүүлэх болон хамтран ажиллах гэрээ хийн ажиллаж байгаа ч үндэслэлгүйгээр гэрээний дүн, хувийг өөрчилж ажилласнаар 19.9 сая төгрөгийн үргүй зардалд зарцуулжээ.
- Санхүүгийн үйл ажиллагаа, зардал үр ашгийн зохистой харьцааг хангаагүй, сүүлийн 3 жилийн дунджаар төлөвлөснөөсөө илүү зарцуулалт хийгдсэн байна.
- Удирдлагын зардлыг төлөвлөн ажиллаж байгаа ч зарим газрууд нь зардлыг төлөвлөж батлуулдаггүй, 2019-2021 онуудад 118.2 сая төгрөгийг илүү зарцуулсан байна.
- Үйл ажиллагааны зардлыг бодиттой төлөвлөж ажиллаагүйгээс 2019-2021 онуудад 2252.8 сая төгрөгийн илүү зарцуулалттай, 227.0 сая төгрөгийн хэмнэлттэй ажилласан үзүүлэлтэй гарч байна.
- Дулааны авлагыг 182.3 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн.
- Өглөгөөр тусгаагүй 15.0 сая төгрөгийн тэтгэмж олгосон.
- Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг зарим онуудад ОНӨААТҮГ-ууд төлөвлөж ажиллаагүй байна.
- Иргэдэд олгосон эргэлтийн болон үндсэн хөрөнгийн 2021 онд эргэн төлөгдөх түрээсийн үлдэгдэл болох 28435970 төгрөгийн авлагыг барагдуулж ажиллаагүй.
- Төрийн өмчит хуулийн этгээдийн үйл ажиллагаанд төрийн байгууллагуудад хяналт шалгалт хийсэн боловч хяналт шалгалтын материалыг хүргүүлж ажилладаггүй байна.
- Санхүүгийн үйл ажиллагаанд тавих төрийн байгууллагуудын хяналт үр нөлөөтэй байна.
- Аймагт үйл ажиллагаагаа явуулж байгаа ХХК, болон ОНӨААТҮГ-уудын дотоод хяналтын ажилтан дотоод хяналт хийсэн гэх боловч хангалтгүй байна
- Мэдээллийн иж бүрэн, үнэн зөв, ил тод байдлыг хангаж ажилласан байгааг дээрх зөрчлүүдээс үзэхэд ХХК, ОНӨХХК, ОНӨААТҮГ-уудын дотоод ажил, тогтолцоо нь харилцан адилгүй байна.

ЗӨВЛӨМЖ:

Аудитын дүн, дүгнэлт нотлох зүйлст үндэслэн дараах зөвлөмжийг өгч байна.

Үүнд:

Нэг: Аймгийн ИТХ-ын дарга Д.Эрдэнэбатад:

1. Суманд үйл ажиллагаа явуулж байгаа ОНӨХХК, ОНӨААТҮГ-уудад ИТХ-аас хяналт тавьж ажиллах үүрэг чиглэл өгч хэрэгжилтийг тооцож байх.

Хоёр. Аймгийн Засаг дарга Б.Ариун-Эрдэнэд:

1. ЗГ-ын 2020-2024 оны төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл, ашиглалт, хамгаалалтыг сайжруулах ажлыг зохион байгуулж, ашиглахгүй байгаа хөрөнгийг шийдвэрлэх тал дээр арга хэмжээ авч хэрэгжилтийг тооцож байх.
2. Аймаг сумдын ОНӨААТҮГ, ОНӨХХК-нд хийх дотоод хяналтыг сайжруулж, хийсэн ажлын тайлан, мэдээ, өгсөн заавар зөвлөгөөг баримтжуулан хүргүүлж, хэрэгжилтийг ханган ажиллаж хэрэгжилтийг тооцох.

Гурав: “Булган мээж” ОНӨХХК-ний ТУЗ-ийн дарга П.Нөхөрлөлбаярт:

1. ТУЗ-ийн компаний засаглалын дотоод журмыг боловсруулж ажиллах.
2. ТУЗ-ийн жилийн ажлын төлөвлөгөө боловсруулж, тайлан мэдээг мэдээлж ажиллах.

Дөрөв. Булган мээж ОНӨХХК-ний гүйцэтгэх захирал Б.Одхүү, Ерөнхий нягтлан бодогч

1. Бэлэн мөнгөний гүйлгээний тайланг үнэн зөв бүрэн, бэлэн мөнгөний орлого, зарлагыг бүрэн тусгаж тайлагнах.
 2. Хүнсний материалын орлогыг холбогдох данс бүртгэлд бүртгэж тайлагнах.
- Тав. Тэшиг сумын ИТХ-ын дарга Б.Ундрахсайханд:
1. “Тэшиг ус” ОНӨААТҮГ-ын үйл ажиллагааны тайлантай танилцаж үүрэг даалгавар өгч, хэрэгжилтийг ханган ажиллах.
 2. *Тэшиг сумын ЗДТГ-ын дансанд бүртгэлтэй “Тэшиг-Ус” ОНӨААТҮГ-ын ашиглаж буй хөрөнгийг балансаас баланст шилжүүлэх*
- Хоёр. Тэшиг сумын Засаг дарга Ж.Гансүхэд:
1. “Тэшиг ус” ОНӨААТҮГ-т эзэмшүүлж байгаа үндсэн хөрөнгийн гэрээг өөрчилж, ААНОАТ-ын тухай хуулийн заалтыг мөрдлөг болгон ажиллах.
- Зургаа: ТУЗ-ын дарга О.Мөнхболдод:
1. ТУЗ-ийн дотоод ажлыг эрх үүргийн дагуу бүрэн хэрэгжүүлж ажиллах.
- Долоо. “Тэшиг ус” ОНӨААТҮГ-ын захирал П.Оюунбат, нягтлан бодогч Э.Оюун-Эрдэнэ нарт:
1. Байгууллагын дүрэм, дотоод журам, бизнес төлөвлөгөөг шинэчлэн боловсруулж батлуулж ажиллах.
 2. Үндсэн хөрөнгө бэлтгэж ажиллах.
 3. Дотоод хяналтаар үүрэг даалгавар өгч биелэлтийг тооцож ажиллах
- Найм. Хутаг-Өндөр сумын ИТХ-ын дарга К.Түмэн-Өлзийд:
1. Нийтийн эзэмшлийн гэрэлтүүлгийг “Ичитхутаг” ОНӨААТҮГ төлбөрийг төлдөг, 2019-2021 онд нийт 7,990,000 төгрөгийг зарцуулсан боловч цахилгааны төлбөр төлнө гэсэн заалт, гэрээ байгуулсан эрх зүйн баримт бичиг байхгүй, эрх зүйн акт үйлдэж ажиллах
- Хоёр. “Ичитхутаг” ОНӨААТҮГ-ын захирал Б.Ариун-Эрдэнэд:
1. Худалдан авах ажиллагааг хууль журмын дагуу зохион байгуулж, акталж устгах, борлуулах үндсэн хөрөнгийн үлдэх өртгийн тооцож үнэлгээ тогтоох эрх бүхий этгээдээр үнэ тогтоолгож ажиллах.
 2. Үйлдвэрийн газрын дотоод хяналтын ажилтан томилж, дотоод хяналтыг сайжруулах.
 3. *“Илчит Хутаг” ОНӨААТҮГ-ын цэвэр ус түгээх, бохир ус зайлуулах тусгай зөвшөөрлийг авах, дээрх үйлчилгээний төлбөрийг авч, орлогыг нэмэгдүүлэх*
- Арав: ХААХИ ОНӨХХК-ний ТУЗ-ийн дарга Д.Жаргалсайханд:
1. ТУЗ-ийн компаний засаглалын дотоод журмыг боловсруулж ажиллах.
- Арван нэг. “ХААХИ” ОНӨХХК-ний гүйцэтгэх захирал Ш.Өлзийхутаг, нягтлан бодогч Х.Үүрцайх нарт:
1. Компаний санхүүгийн үйл ажиллагаанд үр ашгийн тооцоо, шинжилгээг хийж, ерөнхий удирдлагын зардлыг төлөвлөж батлуулж, ТУЗ-ийн дэргэдэх хяналтын зөвлөл байгуулж ажиллах.

Саналд өгсөн тайлбар:

Аймгийн Засаг даргын тамгын газрын 2022 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн 03/746 тоот албан бичгээр илүүлсэн 5 саналыг хүлээн авлаа.

Аймгийн Засаг даргын тамгын газар

Саналд өгөх тайлбар

ОНӨААТҮГ-ын үйл ажиллагаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиар зохицуулагддаг бөгөөд

БуААГ-ын тайлбар 1	тус хуульд ТУЗ-ийн тухай ойлголт байхгүй тул ОНӨААТҮГ-уудад ТУЗ байх шаардлагагүй бөгөөд үүсгэн байгуулагч нь ТУЗ, хяналтын зөвлөлийн үүргийг гүйцэтгэх боломжтой гэсэн санал ирүүлсэн боловч ОНӨААТҮГ-ууд дүрэмдээ ТУЗ-тэй байна гэж заасан, Хутаг-Өндөр сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2015 оны 03 дугаар сарын 23-ны өдрийн 18 дугаар тогтоолын хавсралтаар “Илчит Хутаг” ОНӨААТҮГ дүрэм, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2021 оны 07 дугаар сарын 05-ны өдрийн 56 дугаар тогтоолоор компаний дүрмийг баталсан. Үүсгэн байгуулагч болон ТУЗ нь ОНӨААТҮГ-ын үйл ажиллагаанд хяналт хийгээгүй тул хангалттай зохистой нотлох баримт ирүүлээгүй тул тайлбарыг хүлээн авах боломжгүй.
БуААГ-ын тайлбар 2	Тэшиг сумын ЗДТГ-ын дансанд бүртгэлтэй “Тэшиг-Ус” ОНӨААТҮГ-ын ашиглаж буй хөрөнгийг балансаас баланст шилжүүлэх гэсэн саналыг хүлээн авч зөвлөмжөөр хүргүүллээ.
БуААГ-ын тайлбар 3	Аймагт үйл ажиллагаа явуулж буй орон нутгийн өмчит бүх байгууллагуудад дотоод хяналтын ажилтан ажиллуулах зөвлөмж өгөх гэсэн саналын дагуу аудитын тайлангийн 3.2.2 дахь хэсэгт тусгасан тул шийдвэрийг хэвээр үлдээв.
БуААГ-ын тайлбар 4	Орон тоо, бүтцийг орон тооны давхцалгүйгээр үйл ажиллагааны цар хүрээ, үр ашгийн түвшинг харгалзан тогтоох гэсэн саналыг тайлангийн 2.1.1-д болон хүснэгт 1 дээр тусгасан тул шийдвэрийг хэвээр үлдэв.
БуААГ-ын тайлбар 5	“Илчит Хутаг” ОНӨААТҮГ-ын цэвэр ус түгээх, бохир ус зайлуулах тусгай зөвшөөрлийг авах, дээрх үйлчилгээний төлбөрийг авч, орлогыг нэмэгдүүлэх гэсэн саналуудыг хүлээн авч зөвлөмжид тусгалаа.